



MONGOLIA

Тал нутгийн хангай

**ХАР ЯМААТЫН БАЙГАЛИЙН
НӨӨЦ ГАЗРЫН БАЛТ УРГАМЛУУД**





MONGOLIA



Тал нутгийн хангай

ХАР ЯМААТЫН БАЙГАЛИЙН НӨӨЦ ГАЗРЫН БАЛТ УРГАМЛУУД

2020 он

Эмхтгэсэн:

Дэд профессор Ө. Баярсайхан (МУИС, Шус, Биологийн тэнхим)
Магистр М. Ууганбаяр (ДБХС (WWF) Монгол дахь хөтөлбөрийн газар)
Д. Даваагэрэл (МУИС, Шус, Магистрант)
С. Энхчимэг (МУБИС, Биологийн тэнхим)

Нүүрний зургийг

Б. Гантулга / ДБХС (WWF) Монгол дахь хөтөлбөрийн газар

Ачлагийн (азийн) монос	<i>Padus avium</i> var. <i>asiatica</i> (Kom.) T.C. Ku & B.M. Barthol.	6
Азийн төлөгч өвс	<i>Achillea asiatica</i> Serg.	8
Алтайн түмэн тана	<i>Chamaerhodos altaica</i> (Laxm.) Bunge.	10
Аммань сэдэргэнэ	<i>Convolvulus ammannii</i> Desr.	12
Ацан ажигана, түмэн зангилаа	<i>Stellaria dichtoma</i> L.	14
Бариулт бүйлээс	<i>Amygdalus pedunculata</i> Pall.	16
Буриад гоньд	<i>Carum buriaticum</i> Turcz.	18
Анхил сонгино, гогод	<i>Allium ramosum</i> L.	20
Дорнодын гүзээлзгэнэ	<i>Fragaria orientalis</i> Losinsk.	22
Дунд тавилгана	<i>Spiraea media</i> Schmidt.	24
Дэлхээ сонгино, мангина	<i>Allium prostratum</i> Trev.	26
Дэрэвгэр жиргэрүү	<i>Saposhnikovia divaricata</i> (Turcz.) Schischkin	28
Енисейн шээрэнгэ	<i>Silene jensseensis</i> Willd.	30
Завадскийн тунхуу өвс	<i>Chrysanthemum Zavadskii</i> Herb.	32
Монгол чаргай	<i>Cotoneaster mongolicus</i> Pojark.	34
Мөлхөө шээрэнгэ	<i>Silene repens</i> Patrin.	36
Намгийн дүндэггарав	<i>Parnassia palustris</i> L.	38
Жимсгэнэт алим, өрөл	<i>Malus baccata</i> (L.) Borkh.	40
Сарвуун сонгино	<i>Allium anisopodium</i> Ledeb.	42
Умардын далантовч	<i>Androsace septentrionalis</i> L.	44
Хар үрт Чаргай	<i>Cotoneaster melanocarpus</i> Lodd.	46
Хошоон хунчир	<i>Astragalus melilotoides</i> Pall.	48
Цэх түмэн тана	<i>Chamaerhodos erecta</i> (L.) Bunge.	50
Час улаан долоогоно	<i>Crataegus sanguinea</i> Pall.	52
Эгэл гоньд	<i>Carum carvi</i> L.	54
Эгэл төлөгч өвс	<i>Achillea millefolium</i> L.	56
Эмийн бамбай	<i>Valeriana officinalis</i> L.	58
Австрийн Хависхана	<i>Scorzonera austriaca</i> Willd.	60
Алеппийн малтууш	<i>Geum aleppicum</i> Jacq.	62
Бага буржгар	<i>Thalictrum minus</i> L.	64
Бага хумхаал, Алтанзул	<i>Hemoracallis minor</i> Mill.	66
Британ зоосон цэцэг	<i>Inula britannica</i> L.	68
Бунгийн банга	<i>Crepis bungei</i> Ldb.	70
Буриад хонин зажлуур	<i>Linaria buriatica</i> Turcz.	72
Бяцхан навчит харгана	<i>Caragana microphylla</i> Lam.	74
Галуун гичгэнэ	<i>Potentilla anserina</i> L.	76
Гоёмсог хувиланги	<i>Pedicularis venusta</i> Bge.	78
Гоо улаагана	<i>Ribes pulchellum</i> Turcz.	80
Дагуур тарваган шийр	<i>Thermopsis dahurica</i> Czeffr.	82
Дагуур хатны цэцэг	<i>Cymbaria dahurica</i> L.	84
Жинхэнэ өрөмтүүл	<i>Galium verum</i> L.	86
Имт гичгэнэ	<i>Potentilla bifurca</i> L.	88

Их шүүдэргэнэ	<i>Chelidonium majus</i> L.	90
Ишгүй гичгэнэ	<i>Potentilla acaulis</i> L.	92
Ленийн шар дэмэг	<i>Alyssum lenense</i> Adams.	94
Марал навчит гичгэнэ	<i>Potentilla tanacetifolia</i> Willd.ex Schlecht.	96
Монгол хунчир	<i>Astragalus mongolicus</i> Bunge.	98
Нарийн навчит тарна	<i>Polygonum angustifolium</i> Pall.	100
Нарийн навчит хэргана	<i>Caragana stenophylla</i> Pojark.	102
Нүцгэн намуу, хурган засаа	<i>Papaver nudicaule</i> L.	104
Орос царгас	<i>Medicago ruthenica</i> L. Ldb.	106
Судалт хувиланга	<i>Pedicularis striata</i> Pall.	108
Шивуурт улаагана, тэхийн шээг	<i>Ribes diacanthum</i> Pall.	110
Үлдэн могойн идээ	<i>Sedum aizoon</i> L.	112
Үхэр тарна, дэрвээн тарна, усан шимэлдэг	<i>Polygonum divaricatum</i> L.	114
Хависхана навчит бэриш	<i>Bupleurum scorzonrifolium</i> Willd.	116
Хадны сэрхлиг	<i>Patrinia rupestris</i> (Pall.) Dufur	118
Хоёр ишт Бэриш	<i>Bupleurum bicaule</i> Helm.	120
Хурц салбант хонин зажлуур	<i>Linaria acutiloba</i> Fisch. ex Reichb.	122
Шар гонтог	<i>Erysimum flavum subsp. altaicus</i>	124
Шар хувиланга	<i>Pedicularis flava</i> Pall.	126
Шар царгас	<i>Medicago falcata</i> L.	128
Эмийн багваахай	<i>Taraxacum officinale</i> Wigg.	130
Эгэл буржгар	<i>Thalictrum simplex</i> L.	132
Алтайн согсоот	<i>Heteropappus altaicus</i> (Willd.) Novopokr	134
Ацан цахилдаг	<i>Iris dichotoma</i> Pall.	136
Бар цоохор цахилдаг	<i>Iris tigrisia</i> Bunge ex Ledeb.	138
Булцуут туйпланцар	<i>Phlomis tuberosa</i> L.	140
Бургас навчит банздоо	<i>Saussurea salicifolia</i> (L.) DC.	142
Бургас навчит тавилгана	<i>Spiraea salicifolia</i> L.	144
Бүнгийн яргуй	<i>Pulsatilla bungeana</i> C. A. Mey.	146
Власовын шимтэглэй	<i>Geranium wlassovianum</i> Fish.	148
Говийн ганга	<i>Thymus gobicus</i> Tschern.	150
Гоо юлд	<i>Goniolimon speciosum</i> (L.) Boiss	152
Нарийн навчит зүрхэн цэцэг	<i>Polygala tenuifolia</i> Willd	154
Нарийн навчит хөвөнт	<i>Chamaenerion angustifolium</i> L.	156
Нугын шимтэглэй	<i>Geranium pratense</i> L.	158
Өргөст нохойн хошуу	<i>Rosa acicularis</i> Lindl.	160
Сибирь гүйлс	<i>Armeniaca sibirica</i> (L.) Lam	162
Сибирь зүрхэн цэцэг	<i>Polygala sibirica</i> L.	164
Сибирь хотой	<i>Leonurus sibiricus</i> L.	166
Сибирь шимтэглэй	<i>Geranium sibiricum</i> L.	168
Түмэн навчинцарт ортууз	<i>Oxytropis myriophylla</i> (Pall.) DC	170
Удвал навчит тавилгана	<i>Spiraea aquilegifolia</i> Pall.	172
Уралын чихэр өвс	<i>Glycyrrhiza uralensis</i>	174
Утсан ортууз	<i>Oxytropis filiformis</i> Pall	176
Улбалзуур могойн идээ	<i>Sedum telephium</i> L.	178
Үнэгэн сүүлхэй тарна	<i>Polygonum alopecuroides</i> Turcz. ex Besser.	180

Хиазтай хонгорзалаа	<i>Serratula marginata</i> Tausch.	182
Хижээл сонгино, мангир	<i>Allium senescens</i> L.	184
Хонгор зулгиг хонгорзалаа	<i>Serratula centauroides</i> L.	186
Хөдөөгийн батраш	<i>Mentha arvensis</i> L.	188
Хөдөөгийн сэдэргэнэ	<i>Convolvulus arvensis</i> L.	190
Цацагт үлд өвс	<i>Orostachys fimbriata</i> (Turcz.) A. Berger.	192
Цуулбар нил	<i>Viola dissecta</i> Ldb.	194
Шошлойрхог хошоонгор	<i>Trifolium lupinaster</i> L.	196
Шүдлэг сонгино	<i>Allium bidentatum</i>	198
Баг хонхон цэцэг	<i>Campanula glomerata</i> L.	200
Царсан гүүн хөх	<i>Scutellaria baicalensis</i> Georgi.	202
Монгол догар, ямаан эвэр	<i>Caryopteris mongolica</i> Bge.	204
Нарийн цэцэгт хонхлой	<i>Adenophora stenanthina</i> (Ldb.) Kitag.	206
Нумраа хунчир	<i>Astragalus adsurgens</i> Pall.	208
Ойн дурсгалж цэцэг	<i>Myosotis sylvatica</i> (Ehrh.) Hoffm	210
Сибирь зираа	<i>Lactuca sibirica</i> (L.) Benth. ex Maxim	212
Тагийн гол гэсэр	<i>Aster alpinus</i> L.	214
Хадны бөгтөргөнө	<i>Amblynotus rupestris</i> (Pall.) M.Pop. ex Serg.	216
Цагаалин цахилдаг	<i>Iris lactea</i> Pall.	218
Царсан Гүүн хөх	<i>Scutellaria scordifolia</i> Fisch exSchrank	220
Улиангар	<i>Populus tremula</i> L.	222
Шивүүрт үлд өвс	<i>Orostachys spinosa</i> (L.) C. A. Meyer.	224
Долгиотсон гишүүнэ	<i>Rheum undulatum</i> L.	226
Зөөлөннавчит үлд өвс	<i>Orostachys malacophylla</i> (Pall.) Fisch.	228
Навтгар таван салаа	<i>Plantago depressa</i> Willd.	230
Одой хайлаас	<i>Ulmus pumila</i> L.	232
Олслиг халгай	<i>Urtica cannabina</i> L.	234
Буурал гандбадраа	<i>Veronica incana</i> L.	236
Өргөн навчит тайжийн жинс	<i>Echinops latifolius</i> Tausch.	238
Том навчит дэгд	<i>Gentiana macrophylla</i> Pall.	240
Уртнавчит гандбадраа	<i>Veronica longifolia</i> L.	242
Хулганын гиш	<i>Vicia cracca</i> L.	244
Хэвтээ дэгд	<i>Gentiana decumbens</i> L.f.	246
Цомцогт баавар цэцэг	<i>Scabiosa comosa</i> Fisch. Ex Roem. & Schult.	248
Хар лантанз, тэнэг өвс, согтуу өвс	<i>Hyoscyamus niger</i> L.	250
Цайвар шаргал цагаан туруу, уул өвс	<i>Leontopodium ochroleucum</i> Beauvd.	252
Эгэл цагаан түрүү	<i>Leontopodium leontopodioides</i> (Willd.)	254
Бага хурган чих	<i>Rumex acetosella</i> L.	256
Өмхий буржгар	<i>Carex duriuscula</i> C.A. Mey	258
Ширэг уулалж	<i>Carex duriuscula</i> C.A. Mey	260
Эмийн сөд, сөд өвс	<i>Sanguisorba officinalis</i> L.	262
Манж Гандигар	<i>Sambucus manshurica</i> Kitag.	264
Одой сараана, улаан сараана	<i>Lilium pumilum</i> Delile.	266

АЧЛАГИЙН (АЗИЙН) МОНОС

Латин нэр: *Padus avium var. asiatica* (Kom.) T.C. Ku & V.M. Barthol.

Англи нэр: Wild cherry



УРГАМЛЫН ШИНЖ:

10 м хүртэл өндөртэй, залуу мөчир хар саарал, хөгшин мөчир бараандуу-улаан өнгийн холтос, жилийн найлзуур өтгөн хилэнлэг үслэгтэй юмуу нүцгэн. Навч энгийн бүтэн, 1-1.5 см урт бариултай, илтэс зуувгар юмуу өргөн-өндгөрхүү, богино шовх оройтой, нимгэн, дээд, доод гадаргуу нүцгэн юмуу сийрэг үсэрхэг, хөрөөн шүдлэг захтай. Цэцгүүд цагаан өнгөтэй, анхилуун үнэртэй ба доош унжсан, 10-15 см урт цацаг бацэцэг бүрдүүлдэг. Цоморлигийн навчинцар 3 талтай, захаараа жижиг булчирхайлаг. Яст жимс 7-8 мм урт, бөмбөлөгөрхүү хэлбэртэй, хар өнгөтэй.

Амьдралын хэлбэр: Олон наст модлог ургамал

Ургах орчин: Голын хөндий, эргийн дагуух ой, горхийн эрэг, хусан төгөл, уулын амны хажуу, оёорт ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI сар


Цэцэглэж дуусах хугацаа: VII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 15 хоног.

Балын төрөл: Олон зүйлийн Балан нөөц-156.64 г

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн



АЗИЙН ТӨЛӨГЧ ӨВС

Латин нэр: *Achillea asiatica* Serg.
Англи нэр: Yarrow

УРГАМЛЫН ШИНЖ:

20-50 см өндөр, газар дор найлзуур ба үндэслэг иштэй. Орооцолдсон урт нарийхан үслэгээр бүрхэгдсэн, баг цэцгийнхээ орчимд салаархаг. Үндэс орчмын навчис 10-20 см урт, 1-2 см өргөн, ишнийх арай жижиг, суумал ерөнхийдөө юлдэрхүү хэлбэртэй, урт, үсэрхэг, хошоод юм уу гурвантаа цуулбар өдлөг. Сагс урт шилбэ дээр сууж өтгөн бамбай баг цэцэг үүсгэдэг. Сагсны захын хэлэрхүү цэцгүүд ихэвчлэн ягаавтар, хааяа цагаан, 3 мм орчим урт, голын хоолойрхуу цэцгүүд шар өнгөтэй.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин: Шинэсэн ой, түүний зах, ой, голын эргийн нуга, сөөгөн ширэнгэнд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 43 хоног.

Балын төрөл: Тоосны нөөц- 0.203 г, 0.006-0.069 г.

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал



АЛТАЙН ТҮМЭН ТАНА

Латин нэр: *Chamaerhodos altaica* (Laxm.) Bunge.

Англи нэр: Altai little rose



УРГАМЛЫН ШИНЖ:

Иш 6 см хүртэл өндөр. Намхан, булчирхайлаг үслэгээр бүрхэгдсэн. Модожсон үндэстэй, газрын дээр модожсон хатуу найлзууртай, нягт дэгнүүл үүсгэн бутаар ургадаг. Үндэс орчмын навчис бариултай, бүтэн юмуу 2-3-нтаа хэрчигдсэн, гурвалсан цуулбар, булчирхайлаг болон энгийн үслэгээр өтгөн бүрхэгдсэн. Цэцгүүд ганц нэгээрээ юмуу 3-5-аараа байрладаг. Цэцгийн суудал цоморлогтой адил хонхорхуу, энгийн ба булчирхайлаг үслэгээр битүү хучигдсан. Дэлбэ цагаан юмуу ягаан өнгөтэй. Дэлбийн хэлтэс тонгоруу-өндгөрхүү хэлбэртэй, оройдоо оньтой, цоморлогоос 1.5-2 дахин урт. Үр өндгөрхүү хэлбэртэй нүцгэн.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал

Ургах орчин: Уулын чулуурхаг ба үйрмэг чулуут хээржүү хажуу, элсэрхэг хээр тал, өндөр уулын хээр, хад асганд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: V-VI сар

Цэцэглэж дуусах хугацаа: VI сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн



АММАНЫ СЭДЭРГЭНЭ

Латин нэр: *Convolvulus ammanii* Desr.

Англи нэр: bindweed

УРГАМЛЫН ШИНЖ:

3-5 см өндөр. Дэлхээ юм уу өндиймөл иштэй. Бүхэлдээ налчгар торгомсог үсэрхэг, хуурайсаг ургамал. Навчис шугамархуу, эсвэл шугамархуу-тонгоруу юлдэн хэлбэртэй, цагаан юм уу цайвар ягаан өнгөтэй. Цоморлог 4-7мм урт налчгар-мөнгөлөг үслэгээр өтгөн бүрхэгдсэн, шүдлэгүүд шовх юм уу шовхдуухан оройтой. Дэлбэ 9-15 мм урт, өргөн-өндгөрхүү хэлбэртэй, хатгууртай, өтгөн үсэрхэг.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин: Үйрмэг чулуут болон чулуурхаг хажуу, элсэн ба үйрмэг чулуут цөлийн хээр, алаг өвст хээр, голын эргийн марзлаг нуга, хайрган ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 21 хоног.

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн үнэлгээ- Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал

АЦАН АЖИГАНА, ТҮМЭН ЗАНГИЛАА

Латин нэр: *Stellaria dichotoma* L.
Англи нэр: American chickweed



УРГАМЛЫН ШИНЖ:

Иш 15-30 см өндөр, бүдүүн мөлхөө үндэслэг иштэй, булчирхайт ургамал. Сууриасаа эхлээд ацан салаалсан, бөмбөлөгөрхүү хэлбэрийн бут үүсгэн ургана. Навч зүрхэрхүү- өндгөн, юлдэрхүү юмуу шугамархуу хэлбэртэй, 0.5-2 см урт, 12 см өргөн, хурц оройтой, суумал. Ацан салаалсан иш мөчрийн үзүүрт байрласан олон цэцэгтэй ба тэдгээр нь урт шилбэн дээр бэхлэгддэг. Цоморлогийн навчинцар юлдэрхүү, шовх, нарийн хальсан эмжээртэй. Дэлбийн хэлтэс цагаан өнгөтэй, цоморлогтойгоо тэнцүү юмуу түүнээс 1.5-2 дахин урт. Хонхорцог бөөрөнхийвтэр-өндгөрхүү, цоморлогоосоо богино дотроо 2-5 үртэй.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал


Ургах орчин: Хээрийн чулуурхаг, хуурай хажуу, нураг хад чулуу, заримдаа хайрга, элсэнд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII сар

Балын төрөл: Олон зүйлийн Ургамлын балан нөөц- 0.006 г. Зөгийн аж ахуйн-Амтат шүүст-тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн



БАРИУЛТ БҮЙЛЭЭС

Латин нэр: *Amygdalus pedunculata* Pall
Англи нэр: Long-stemmed almond



УРГАМЛЫН ШИНЖ:

0.5-1.5 м өндөртэй. Саравгар салаа мөчиртэй, олон богиноссон найлзууртай, найлзуур хүрэвтэрээс хар сааралдуу хүрэн. Навчис богиноссон найлзуур дээр багцалж байрлах бөгөөд жилийн найлзуур дээр цувраа байрлана; илтэс зууван, дүгэрэгдүү юмуу тонгоруу өндгөрхүү, 1-3 см урт, 2 талдаа үстэй, доод талдаа ногоовтор, дээд тал нь хар ногоон, өргөн шаантган суурьтай, жигд бус хөрөөлөг захтай. Цэцэг ганцаар байрлах ба навчлахын өмнө дэлгэрдэг, 1-1.5 см голчтой. Дэлбийн хэлтэс ягаан, дугаригдуу 8-10 мм урт. Яст жимс улаавтар, дугаригдугаас зууван, өтгөн үстэй; мезокарп нимгэхэн, хуурай, эндокарпаас саланги, жимс боловсрох үед хагарамхай. Үр хүрэндүү шар, өргөн өндгөрхүү.

Амьдралын хэлбэр: Олон наст сөөг ургамал
Ургах орчин: Хээрийн ба цөлийн бүсийн чулуурхаг хажуу, сайрын оёор болон зах, хурдасын овоолго, элсний зах, хад асганд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар


Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 14 хоног

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн



БУРИАД ГОНЬД

Латин нэр: *Carum buriaticum* Turcz.

Англи нэр: Caraway

УРГАМЛЫН ШИНЖ:

15-30 см өндөр. Шүхэр ороолтгүй, эсвэл 1-3 навчинцартай, шилбэ нь өөр хоорондоо тэнцүү шүхрэнцэр ороолтонцортой, түүний навчинцар юлдэрхүү, ирмэгээрээ сарьслаг цайвар. Дэлбийн хэлтэс цагаан.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин: Эргийн ба хээрийн нуга, нугархаг задгай хажууд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VII-VIII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VIII-IX сар

Балын төрөл: Олон зүйлийн

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал

АНХИЛ СОНГИНО, ГОГОД

Латин нэр: *Allium ramosum* L.

Англи нэр: Chinese Chives



УРГАМЛЫН ШИНЖ:

Иш 20-50 см өндөр, эгц босоо. Навчис нь ишний суурьт байрласан, нарийн шугамархуу хэлбэртэй, 2-4 мм өргөн. Цэцэг одорхуу цагаан, олноороо шүхэр баг цэцэгт нэгддэг. Цэцгийн шилбэ 3 см урт, шадар эрхтнээсээ 2-3 дахин урт. Шадар эрхтэн 5-9 мм урт. Дохиур нь шадар эрхтнээсээ 2 дахин богино. Үр жимс нь хонгорцог. 1-3 юмуу хэд хэдэн сонгинолог булцуутай. Энэ булцуу нь бор саарал өнгийн торлог бүрхэвчтэй.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал

Ургах орчин: Хуурай хээр, уулын чулуурхаг болон чулуут хажуу, хад чулуу, голын хайрганд ургана.


Цэцэглэж эхлэх хугацаа: VI сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн



ДОРНОДЫН ГҮЗЭЭЛЗГЭНЭ

Латин нэр: *Fragaria orientalis* Losinsk.

Англи нэр: Wild strawberry



УРГМАЛЫН ШИНЖ:

Цэцэглэх иш 10-30 см өндөр, навчны бариулын адил урт сэрэвгэр үсэрхэг, газрын дээр үндэслэдэг мөлхөө найлзууртай. Гурвалсан нийлмэл навчтай, навчинцар өндгөрхүү-ромбон хэлбэртэй, талдаа 6-9 том шүдлэгтэй, дээд гадаргуу сийрэг үсэрхэг, доод гадаргуу өтгөн торгомсог үсэрхэг. Цэцэг 15-20 (30) мм голчтой, цагаан өнгөтэй, тавчилсан бүтэцтэй ба 3-7-оороо сийрэг багцэцэг бүрдүүлдэг. Цоморлиг дэлбээс богино ба жимслэх үест гадагш эргэдэг. Жимс өндгөрхүү юмуу уртавтар хэлбэртэй, улаавтар зөөлөн, хялбар унамтхай.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал

Ургах орчин: Ойт болон ойт хээрийн бүслүүрт шинэсэн ой, холимог ой, төгөл, ойн зах, ойн нугад ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 20 хоног

Балын төрөл: Олон зүйлийн Тоосны нөөц- 0.021 г, балан нөөц- 0.002 г

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн

ДУНД ТАВИЛГАНА

Латин нэр: *Spiraea media* Schmidt.

Англи нэр: Oriental spiraea



УРГМАЛЫН ШИНЖ:

1.5 м хүртэл өндөр, эгц босоо сөөг ургамал. Иш улаан-хүрэн, хөгшин мөчир саарал-хүрэн юмуу хар-хүрэн болдог, нарийхан, бөөрөнхийдүү, нүцгэн. Нахиа хүрэвтэр, өндгөрхүү, цөөхөн хайрстай, хурц оройтой. Навчис зуувгараас бараг юлдэрхүү, 1-4 см урт, 0.5-2 см өргөн, хоёр тал нь нүцгэн, тод ногоон, шаантгархуу суурьтай, бүтэн захтай юмуу 2-5 хөрөөн шүдтэй, хурц юмуу хааяа мохоо оройтой. Цацаг баг цэцэг шүхрэрхүү, 9-15 цэцэгтэй. Цоморлигийн навчинцар жимслэх үед гадагш дэрэвгэр. Гипанти өргөн хонхорхуу. Дэлбийн хэлтэс цагаан, дугаригдуу, 3-4.5 мм уртаасаа бараг өргөн, нүцгэн. Хэтэвч шулуун дэрэвгэр, үсэрхэг. Багана нь хэтэвчийн нуруун талаас гарсан.

Амьдралын хэлбэр: Олон наст сөөг ургамал
Ургах орчин: Сийрэг шилмүүст болон холимог ой, ойн зах, сөөг дунд, голын эрэг, чулуурхаг хажуу, ам хавцлын оёорт ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI сар


Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 31 хоног

Балын төрөл: Олон зүйлийн Балан нөөц- 0.584 г, 0,076 г

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн



ДЭЛХЭЭ СОНГИНО, МАНГИНА

Латин нэр: *Allium prostratum* Trev.

Англи нэр: Wild Onion



УРГАМЛЫН ШИНЖ:

10-25 см өндөр, иш нарийхан, туяхан, өндиймөл. Навчис 5-8. Цэцэг улбар-ягаан, цэцгийн шилбэ шадар эрхтнээсээ 2-3 дахин илүү, сийрэг тал бөөрөнхий шүхэрт байрлана.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг
Ургах орчин: Хээрийн чулуурхаг болон уулын чулуурхаг хажуу, хайрга, марзлаг хээрийн нугад ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн



ДЭРЭВГЭР ЖИРГЭРҮҮ

Латин нэр: *Saposhnikovia divaricata* (Turcz.) Schischkin
Англи нэр: Siler



УРГАМЛЫН ШИНЖ:

30-80 см өндөр сууриасаа ихэд салаархаг, нүцгэн иштэй. Үндэсний хүзүүвч ишний угийн навчны хүрэн үлдэгдлээр нягт хучигдсан. Үндэс голлосон, голчоороо 1.5-2 см. Салааголиштэйгээ бараг тэнцүү. Ишний угийн навчис богино бариултай, ерөнхий хэлбэр нь гонзгойвтор, хошоод гурвантаа өдлөг цуулбар, суурь руугаа өргөсөж угларга болно. Үндэс орчмын навчис олон. Навчис хошоод юм уу гурвантаа хагалбар өдлөг. Навчны төгсгөлийн эрэмбийн сегмент юлдэрхүү юм уу урвуу-өндгөрхүү, 8-20 мм урт 1.5-8 мм өргөн. Шүхэр 2-8 см голчтой, адил урттай 5-8 шилбэтэй. Шүхрэнцэр 4-10 цэцэгтэй. Нуухны навчинцаргүй. Үр жимс өндгөрхүү, хурц гүргэр хавиргатай. Үр жимс нүцгэн, 5-7 мм урт 3-3.5 мм өргөн.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс
Ургах орчин: Хайрга чулуутай хээр, хялганат болон үетэн алаг өвст хээр, сөөглөг буттай хээр, ойтой залгаа орших хээрийн экосистемд ургана.


Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Тоост- амтат шүүст ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал



ЕНИСЕЙН ШЭЭРЭНГЭ

Латин нэр: *Silene jensseensis* Willd.

Англи нэр: Campion

УРГАМЛЫН ШИНЖ:

15-60 см өндөр. Үндэслэг иштэй, цайвар ногоон өнгийн ургамал, навчис шугамархуу юмуу шугаман юлдэрхүү. Цэцэг цагаан, эгц, босоо, цоморлиг хурц юмуу хурцавтар, нилээд урт шүдлэгтэй, цэцгийн дагавар юлдэрхүү. Үр жимс хонхорцог.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал

Ургах орчин: Уулархаг-хээрийн бүслүүрт хад асга, уул толгодын чулуурхаг ба үйрмэг чулуут хээржүү хуурай хажууд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII сар

Балын төрөл: Олон зүйлийн Ургамлын балан нөөц- 0.012 г

Таримал/Байгалийн: Байгалийн

ЗАВАДСКИЙН ТУНХУУ ӨВС

Латин нэр: *Chrysanthemum Zavadskii* Herb.

Англи нэр: *Zawadzki chrysanthemum*



УРГАМЛЫН ШИНЖ:

15-60 см өндөр, Богиноссон үндэслэг иштэй, 2 салаалсан богино ба энгийн үслэгээр бүрхэгдсэн. Ганц нэгээрээ юм уу цөөн тоотой эгц босоо, навчирхаг, энгийн иштэй. Үндэс орчмын ба доод хэсгийн навчис дунд навчисаас том, илтэс нарийн шугамархуу салбангуудад өдлөн хэрчигдсэн, шовх оройтой. Сагс ишний үзүүр болон хажуугийн мөчрийн оройд ганц нэгээрээ юм уу цөөнөөрөө байрлана. Ороолт 10-25 мм голчтой, 4.5-6 мм орчим өндөр, үсэрхэг юм уу нүцгэн гадаргуутай. Навчинцар цайвар юм уу хар бор өнгийн хальсархаг өргөн захтай. Хэл цэцгүүд янз бүрийн туяа бүхий цагаан ягаан өнгөтэй. 1.8-3 мм урт дэлбийн хоолойтой, 15-30 мм урт, 3-5 мм өргөн дэлбэтэй. Үр гонзгой бөөрөнхий, 2.5 мм урт, 0.6 мм өргөн, цомцоггүй. Эмийн ач холбогдолтой ургамал.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс
Ургах орчин: Ой, ойт хээрийн бүслүүрт шинэсэн ой, ойн зах ба нуга, хайрга, хад чулуутай хажууд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар


Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 15 хоног.

Балын төрөл:

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал



МОНГОЛ ЧАРГАЙ

Латин нэр: *Cotoneaster mongolicus* Pojark.

Англи нэр: Mongolian Cotoneaster



УРГАМЛЫН ШИНЖ:

1.8 м хүртэл өндөр. Иш саравгар, улаавтар хүрэн, бөөрөнхий, бахим бөх, эхлээд цагаан үслэгтэй, сүүлдээ нүцгэрдэг. Навчис цувраа, энгийн, гонзгой-зууван, 2-3 см урт, 1-1.8 см өргөн, доод талдаа саарал эсгийрхүү үслэгтэй, дээд тал цайвар, нүцгэн юмуу үл ялиг үслэгтэй, бүтэн захтай, шаантгархуу суурьтай, ихэвчлэн мохоо оройтой. Бамбай баг цэцэг 3-6 цэцэгтэй. Цэцэг 9-10 мм голчтой. Цоморлигийн навчинцар бараан улаан, гурвалжин. Дэлбийн хэлтэс 5, дэрэвгэр, цагаан, дугаригдуу. Жимс бараан улаан юмуу гүн улаан, бөөрөнхий-өндгөрхүү, 7-9 мм, саарал өнгөтэй, дотроо – ястай (үртэй).

Амьдралын хэлбэр: Олон наст сөөг ургамал

Ургах орчин: Хээрийн үйрмэг чулуут ба чулуурхаг хажуу, хад, уулын хажуу ба толгодын сөөгөн шугуйд ургана.


Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VIII-IX сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн



МӨЛХӨӨ ШЭЭРЭНГЭ

Латин нэр: *Silene repens* Patrin.
Англи нэр: Creeping catchfly

УРГАМЛЫН ШИНЖ:

Иш 20-60 см өндөр. Мөлхөө урт, нарийхан үндэслэг иштэй, сууриараа өндиймөл, салаархаг, богино налсан махир үслэгээр хучигдмал. Навч юлдэнгээс шугаман хэлбэртэй, 2-7 см урт, 2-7 мм өргөн, шовх оройтой. Ишний дээд хэсгийн навчны өвөрт богино, нарийн залаархуу хэлбэртэй, цэцгийн дагавар өвслөг, зууван-юлдэн хэлбэртэй, цэцгийн шилбэ цоморлогоос богино. Цоморлог 11-16 мм урт, дээд хэсэгтээ цүндгэр, богино үсэрхэг, ягаан судалтай, захаараа хальслаг эмжээр бүхий шүдлэгүүдтэй. Дэлбийн хэлтэс цайвар шаргал, 1/3 хүртэл цуулбарлагдсан, өргөн өндгөрхүү хэлбэртэй. Хонхорцог өндгөрхүү 6-7 мм урт.


Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал
Ургах орчин: Хээрийн болон нугархаг хажуу, сийрэг ой, тэдгээрийн зах, ойн нуга, сөөг дунд, голын эргээр, ширэгжсэн хад, чулуу, элсэнд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII сар

Балын төрөл: Олон зүйлийн Ургамлын балан нөөц- 0.001 г.

Таримал/Байгалийн: Байгалийн



НАМГИЙН ДҮНДЭГГАРАВ

Латин нэр: *Parnassia palustris* L.

Англи нэр: Marsh grass of Parnassus



УРГАМЛЫН ШИНЖ:

Богинохон үндэслэг иштэй, үндэс орчмын навчтай ургамал. Үндэс орчмын навч өндгөрхүү хэлбэртэй, зүрхэн хэлбэртэй, зүрхэн суурьтай. Ишний дунд хэсэгтээ 10-30 (35) см өндөр, ишний дунд хэсэгт ганц навчтай ба энэ нь хэлбэр, хэмжээгээрээ үндэс орчмынхтой адил. Цоморлигийн навчинцарууд салангид, дийзэрхүү дэлгэмэл, өргөн-юлдэн хэлбэртэй, урт нь өргөнөөсөө 2-3 дахин богино. Цэцэг цагаан өнгөтэй, хэлтэс дийзэрхүү буюу тавгархуу хэлбэртэй дэлгэмэл, тууш шаргал судалтай, зууван, шаантган суурьтай, цоморлогоосоо 2 дахин урт. 10 дохиуртай ба тэдгээрийн 5 нь дутмаг. Үрэвч суумал 4 амсартай. Хонхорцог өргөн-өндгөрхүү, 4 хавтсаар нээгдэнэ.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал

Ургах орчин: Бараг бүх бүс бүслүүрийн чийглэг, намгархаг, марзат нуга, намгийн зах, гол, булгийн эрэг, хайрга, сөөгөн дунд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Балын төрөл: Олон зүйлийн Тоосны нөөц- 0.029 г, балан нөөц- 0.016 г

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн

ЖИМСГЭНЭТ АЛИМ, ӨРӨЛ

Латин нэр: *Malus baccata* (L.) Borkh.

Англи нэр: Siberian crab apple



УРГАМЛЫН ШИНЖ:

10-12 м хүртэл өндөр, богино тахиралдсан гол иштэй, бөөрөнхий титэмт бэсрэг мод. Залуу найлзуур улаавтар хүрэн, бөөрөнхий нүцгэн. Нахиа улаавтар хүрэн, өндгөрхүү, хайрс нь захаараа эсгийрхэг үслэгтэй. Навчны байриул 2.5 см. Навчис өргөн зуувгар юмуу өндгөрхүү, 3-8 см урт, 2-3.5 см өргөн, нүцгэн юмуу залуу байхдаа үл мэдэг үсэрхэг, сууриараа шаантгархуу юмуу дугуй, хөрөөлөг шүдлэг захтай, орой нь шовхорсон. Найлзуурын үзүүрт 4-6- гаар багцалж, бамбайрхуу шүхэр баг цэцэг үүсгэнэ. Цэцгийн шилбэ 1.5-4 см, нарийхан, нүцгэн. Цэцэг 3-3.5 см голчтой. Гипанти хонхорхуу. Дэлбийн хэлтэс цагаан, 2-2.5 см, мохоо-дугуй оройтой. Жимс бөөрөнхий, 0.8-1 см хүртэл голчтой, шар юмуу улаан, жимсний шилбэ 3-4 см урт.

Амьдралын хэлбэр: Олон наст модлог ургамал
Ургах орчин: Ой болон ойт хээрийн бүслүүрт нарсан ой, хусан төгөл, голын эргийн ой, голын хөндий, сөөгөн шугй, уулын хажуу биеэр ургана.


Цэцэглэж эхлэх хугацаа: V сар

Цэцэглэж дуусах хугацаа: VI сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 16 хоног

Балын төрөл: Олон зүйлийн балан нөөц- 7.75 г
Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн



САРВУУН СОНГИНО

Латин нэр: *Allium anisopodium* Ledeb.

Англи нэр: Thread-leaf chive



УРГАМЛЫН ШИНЖ:

Иш 20-40 см өндөр. Хэвтээ үндэслэг иш дээр хэд хэдээрээ бэхлэгдсэн сонгинолог булцуутай. Булцуу боровтор бага зэрэг ширхэглэг хайрстай. Цэцгийн шилбэ хоорондоо чацуу биш, шадар эрхтнээсээ 3-7 дахин урт, шүхэр сийрэг, багцархуу, шадар эрхтний навчинцар улбар ягаан, дундаа шаантаг хэлбэрийн зузааралтай.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал

Ургах орчин: Хээрийн чулуурхаг хадтай хажуу, хуурай болон цөлөрхөг хээр, элс хайрганд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн

УМАРДЫН ДАЛАНТОВЧ

Латин нэр: *Androsace septentrionalis* L.

Англи нэр: Northern rockjasmine



УРГАМЛЫН ШИНЖ:

35 см хүртэл өндөр ургадаг. Иш мөчиргүй. Навч үндэс орчим байрладаг, дээд хэсгээрээ бага зэрэг өргөссөн, уртавтар юм уу юлдэн хэлбэртэй, шүдэрхэг, нүцгэн эсвэл богино үсэрхэг. Цэцгийн сум иш олноороо, хааяа ганц нэгээрээ. Богино салаалсан үслэгээр хучигдсан. Дагавар навч юлдэн, шовх, 3 мм хүртэл урт, цэцгийн шилбэнээс олон дахин богино үсэрхэг. Цэцгийн шилбэ нарийхан, сум шинээс хэд дахин богино. Цоморлог хонхорхуу, нүцгэн, өндгөрхүү-хавиргалаг. Дэлбэ цагаан, цоморлогтой тэнцүү юм уу дөнгөж урт, 4-5 мм голчтой, салбангууд тонгоруу-өндгөрхүү хэлбэртэй, заримдаа үл мэдэг долгиотсон юм уу үзүүртээ бага зэргийн оньтой. Хонхорцог жимстэй. Үр хар-хүрэн өнгөтэй, зөв биш гурвалжин хэлбэртэй, тэнцүү бус 5 талтай, бага зэргийн товруурхаг гадаргуутай.

Амьдралын хэлбэр: Нэг наст өвслөг алаг өвс
Ургах орчин: Хээржүү болон нугархаг хажуу, голын эргийн элсэрхэг хайрга, шинэсэн ой, нураг, хад цохионы сүүдэрт ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар


Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Цэцэглэл үргэлжлэх өдөр: 38 хоног

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал



ХАР ҮРТ ЧАРГАЙ

Латин нэр: *Cotoneaster melanocarpus* Lodd.

Англи нэр: Cotoneaster



УРГАМЛЫН ШИНЖ:

2 метр өндөртэй сөөг ургамал. Навч 2-4 (6) см урт, 1.5-2.5 см өргөн, өндгөрхүү юмуу зууван, мохоо боловч оройдоо оньтой, ургал найлзуур дээрхи навчис нь хурц, доод гадаргуу ноосорхог шаргал юмуу цайвар зөөлөн үсжилттэй. Цэцэг цагаан ягаан, цэцгүүд 2-15-аар сийрэг цацаг юмуу цацгархуу залаа баг цэцэг үүсгэнэ. Цэцгийн шилбэ гудгар, үсэрхэг. Цэцгийн суудал нүцгэн. Цоморлигийн навчинцар гурвалжин ирмэгээрээ сормууслэг. Жимсгэнэ голдочоороо 7-9 мм, хар, цайвар саарал өнгөтэй, дотроо 2-3 үсэрхэг ястай (үртэй).

Амьдралын хэлбэр: Олон наст сөөг ургамал

Ургах орчин: Хээрийн чулуурхаг ба хадтай хажуу, хотос хонхор, сөөгөн шугуй, хусан төгөл, шинэс ба нарсан ой, ойн захаар ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI сар

Цэцэглэж дуусах хугацаа: VIII-IX сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 21 хоног

Балын төрөл: Олон зүйлийн


Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн

ХОШООН ХУНЧИР

Латин нэр: *Astragalus melilotoides* Pall.

Англи нэр: Milkvech



УРГАМЛЫН ШИНЖ:

Голлосон үндэстэй. 40-90 см өндөр, навчинцар 3-4 хос, голдуу утсархуу шугаман гонзгойвтор, тонгоруу-шаантгархуу, мохоо юмуу оньтой, 7-15 мм урт, 2-5 мм өргөн. Цэцэг цайвардуу ягаан юмуу цагаан өнгийн сийрэг цацаг баг цэцэг үүсгэдэг. Буурцаг өргөн тонгоруу-өндгөрхүү.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал

Ургах орчин: Хээрт, хээржүү нуга, хээр дэхь голын хөндий, чулуурхаг, хайргархаг хажуу, элсэрхэг хээр, атар шазар болон шуудууны дагуу ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VIII сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн



ЦЭХ ТҮМЭН ТАНА

Латин нэр: *Chamaerhodos erecta* (L.) Bunge.

Англи нэр: Little Groundrose

УРГАМЛЫН ШИНЖ:

Үндэс нь нарийн модожсон, голдуу ганц эгц босоо, 5-6 см өндөр навчирхаг иштэй. Үндэс орчмын навчис 4.5 см хүртэл урт, нарийхан шулуун мохоодуу салбанцартай. Цэцэг дихази маягийн баг цэцэг үүсгэдэг, дэлбэ цагаан юмуу цайвар ягаан.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал

Ургах орчин: Элсэрхэг хээр тал, чулуурхаг ба үйрмэг чулуут хээржүү хажуу, хуурай шинэсэн ой, сайрын оёор, хад асга, эргийн хайрганд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн

ЧАС УЛААН ДОЛООГОНО

Латин нэр: *Crataegus sanguinea* Pall.

Англи нэр: Redhaw Hawthorn, Siberian Hawthorn



УРГАМЛЫН ШИНЖ:

2-4 м өндөртэй. Өргөс хатгууртай, тагдгар ургадаг. Залуу мөчир улаавтар хүрэн, хөгшин нь саарал хүрэн холтостой. Иш бөөрөнхий, залуудаа сийрэг үслэгтэй, удалгүй нүцгэрдэг. Нахиа улаавтар хүрэн, гурвалжин-өндгөрхүү, нүцгэн. Навчны бариул 1.5-2 см. Навчис өргөн өндгөрхүү юмуу ромбон өндгөрхүү, 3-6 см урт, 3.5-5 см өргөн, 3-5 бяцхан салбантай. Доод талдаа судлын дагуу сийрэг үслэгтэй, дээд талдаа үсэрхэг, шаантгархуу суурьтай, давхар хөрөөн шүдлэг захтай. Бамбай баг цэцэг 2-3 см голчтой, олон цэцэгтэй. Цэцэг 8 мм орчим голчтой. Гипанти хонхорхуу, нүцгэн. Дэлбийн хэлтэс цагаан, гонзгой, 5-6 мм. Дохиур 20, тоосовч улаан. Жимс өтгөн улаан, бөөрөнхийдүү, 1 см орчим голчтой, цоморлигийн навчинцар хагдардаггүй, 3-4 ястай (үртэй), хоёр талдаа үрчлээстэй.

Ургах орчин: Голын хөндий, хусан төгөл, задгай ам, ойн захаар ургана.

Амьдралын хэлбэр: Олон наст сөөг ургамал

Цэцэглэж эхлэх хугацаа: VI

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн



ЭГЭЛ ГОНЬД

Латин нэр: *Carum carvi* L.

Англи нэр: Caraway, Meridian Fennel, Persian Cumin

УРГАМЛЫН ШИНЖ:

15-30 см өндөр. Шүхэр ороолтгүй, шилбэ нь тэнцүү бус шүхрэнцэр бас ороолтонцоргүй. Дэлбийн хэлтэс ихэвчлэн ягаавтар.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин: Голын хөндий, эргийн хужирлаг нуга, хайрга, шинэсэн ой, түүний зах, эргийн сөөгөн ширэнгэнд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VII-VIII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VIII-IX сар

Балын төрөл: Олон зүйлийн

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал

ЭГЭЛ ТӨЛӨГЧ ӨВС

Латин нэр: *Achillea millefolium* L.

Англи нэр: Common yarrow



УРГАМЛЫН ШИНЖ:

40-100 см өндөр. Навч хошоод-гурвантаа өдлөг цуулбар. Навчны гол судал 1-2 мм өргөн, салбангууд бие биенээсээ 3-10 мм зайтай, тэдгээрийн салбанцарууд 0.5-1.5 мм өргөн. Цэцэг цагаан хааяа ягаан.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин: Нуга, шинэсэн ба хусан ой, тэдгээрийн зах, голын эрэг, суурин газар ба замын дагуу ургана.


Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Балын төрөл:

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал



ЭМИЙН БАМБАЙ

Латин нэр: *Valeriana officinalis* L.

Англи нэр: Garden heliotrope



УРГАМЛЫН ШИНЖ:

Иш 60-120 см өндөр, үсэрхэг. Навч зузаавтар, үсэрхэг, өдлөг хагалбар ба үзүүрийн болон хажуугийн 3-8 хос салбантай, үзүүрийнх нь хажуугийнхаас том, салбанцарууд юлдэрхүү хэлбэртэй, бүтэн юм уу шүдэрхэг. Нягт шигүү, эсвэл сийрэгдүү бамбай юм уу бамбайрхуузалаа баг цэцэгтэй. Цэцэг цайвар ягаан, ягаан юм уу хааяа цагаан өнгөтэй, хоолойрхуу-юулүүрэн дэлбэтэй. Дохиур 3, амсар 3 далбантай. Үр оройдоо өдөн үслэгээс бүтсэн цомцогтой.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг

Ургах орчин: Ойн бүслүүрт шинэсэн ой, тэдгээрийн зах, хусан төгөл, ойн ба татмын нуга, боролж, бургасан шугуй, сүүдэрсэг ам, хадны суурь хавиар ургана.


Цэцэглэж эхлэх хугацаа: VI- сар

Цэцэглэж дуусах хугацаа: VIII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 41 хоног.

Балын төрөл: Олон зүйлийн Балан нөөц-0.018 г. Зөгийн аж ахуйн үнэлгээ- Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн



АВСТРИЙН ХАВИСХАНА

Латин нэр: *Scorzonera austriaca* Willd.

Англи нэр: Austrian serpent-root

УРГАМЛЫН ШИНЖ:

Иш 3.5- 30 см өндөр, энгийн юм уу мөчирлөг, нүцгэн. Навч шугаман юм уу шугамархуу-юлдэн, 2-10 (15) мм өргөн, богино бариултай, урт шовх оройтой, хавтгай юм уу долгиолог, шулуун юм уу бага зэргийн матигар. Сагс 2-3.5 см урт. Цэцгүүд шар гадна талаараа ягаавтар судалтай. Бүдүүн босоо үндэстэй, үндэсний хүзүү өнгөрсөн оны навчны ширхэгдсэн үлдэгдлээр хучигдсан.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг

Ургах орчин: Үйрмэг чулуутай ба чулуурхаг хээр, нугажуу хажуу, хээр, эрэг орчмын нуга, ойн зах, хад, нуранги асанд ургана.


Цэцэглэж эхлэх хугацаа: VII- сар

Цэцэглэж дуусах хугацаа: VIII сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн



АЛЕППИЙН МАЛТУУШ

Латин нэр: *Geum aleppicum* Jacq.

Англи нэр: Yellow avens

УРГАМЛЫН ШИНЖ:

40-80 см өндөртэй. Иш эгц босоо, ширүүн үсэрхэг. Ховор тохиолдолд нүцгэн. Навч дагавар навчтай, ногоон, өндгөрхүү, том илтэстэй, өдлөг нийлмэл. Баг цэцэг ишний төгсгөлд байрладаг. Цэцэгс 1-1.7 см диаметртай. Цоморлиг өндгөрхүү-гурвалжин, дэлбэ шар, хагас дугуй, үзүүрлүүгээ мушгирсан. Үр тонгоруу өндгөрхүү, жимслэх үед битүү ширүүн үсээр хучигддаг, үсний урт 1 мм.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал

Ургах орчин: Эргийн сөөгөн ширэнгэ, шугуй, голын эрэг, чийглэг эрэг, нуга, хусан төгөлд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: IX сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн

БАГА БУРЖГАР

Латин нэр: *Thalictrum minus* L.
Англи нэр: Lesser meadow rue

УРГАМЛЫН ШИНЖ:

10-30 см өндөртэй. Иш эгц босоо, нүцгэн. Навчны бариул 4 см, илтэс дөрвөлсөн өдлөг, 20 см өргөн тонгоруу өндгөрхүү эсвэл өргөн дөрвөлжин, нимгэн, арьслаг, захаараа ногоовтор өнгөтэй. Баг цэцэг шүхэр. Цэцгийн шилбэ 3-30 мм. Цоморлиг 4, унамтгай, ногоон холилдсон, өргөн зуван 3.5 мм. Дохиур олон 6 мм, шилбэ хялгасан, тоосовч өргөн гонзгой, 2 мм үзүүр шовх. Үр боловсрох орон 3-5, амсар гурвалжин далавчирхуу. Үр өргөн зуван 3.5 мм, 8 судалтай.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал

Ургах орчин: Шинэсэн ой, хусан ой, ойн зах болон нуга, сөөгөн шугуй, нугархаг хажуу, голын эргийн нугад ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII сар

Балын төрөл: Олон зүйлийн Ургамлын балан нөөц- 0.046 г

Зөгийн аж ахуйн ангилал: Тоост-амтат шүүст ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн



БАГА ХУМХААЛ, АЛТАНЗУЛ

Латин нэр: *Hemerocallis minor* Mill.

Англи нэр: Small Daylily



УРГАМЛЫН ШИНЖ:

20-50 см өндөр, богиноссон мөлхөө үндэслэг иштэй. Бүх навч үндэс орчимд байрладаг, шугамархуу хэлбэртэй, 5-10 мм өргөн, ишнээс богино юмуу түүнтэй чацуу. Ишний үзүүрт 2-5 цэцэгтэй. Цэцгийн дагавар хальсархуу ба юлдэн хэлбэртэй. Шадар эрхтэн юүлүүр хэлбэртэй, тод шар өнгөтэй, 10 см хүртэл урт. Хонхорцог өндгөрхүү, 2-3 см урт. Өвөл навчаа гөвдөг.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал

Ургах орчин: Ойн зах, нуга, нугархаг уулын хажуу, хээрийн нуга, сөөг дунд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI


Цэцэглэж дуусах хугацаа: VII

Балын төрөл: Олон зүйлийн

Ургамлын балан нөөц: 0.046 г

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст, тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн



БРИТАНИ ЗООСОН ЦЭЦЭГ

Латин нэр: *Inula britannica* L.
Англи нэр: British elecampane

УРГАМЛЫН ШИНЖ:

15-65 см өндөр. Мөлхөө үндэслэг иштэй. Дээд хэсэгтээ салаалсан гурвилаг, доод хэсэгтээ улаавтар өнгөтэй. Ишний дээд ба дунд хэсгийн навчис 2.5-9 см урт, 0.6-2.2 см өргөн, юлдэрхүү хэлбэртэй, зурхэрхүү өргөн сууриараа ишээ зууж байрладаг, дээд гадаргуу цөөн сийрэг үсэрхэг, доод гадаргуу өтгөн үслэг ба булчирхайлаг. Хэд хэдэн сагснууд нийлж бамбай багцэцэг бүрдүүлэх ч хааяа ганц нэг сагстай байх тохиолдол байна. Сагс 3-4.5 см голчтой, шар өнгөтэй. Эмийн ач холбогдолтой ургамал.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин: Гол, нуур, горхийн мараалаг эрэг, булгийн ойролцоох хужиртай нуга, эргийн харгиа, хайрганд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Балын төрөл:

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал

БУНГИЙН БАНГА

Латин нэр: *Crepis bungei* Ldb.
Англи нэр: Crepis

УРГАМЛЫН ШИНЖ:

10-40 см өндөр. Цэцэг ягаан, иш голдуу үзүүрүүдээ салаалсан, 2-7 сагстай. Доод навч суумал.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин: Эрэг орчмын нуга, хайрга, бургасан шугуй, эрэг орчмын мараалаг нугад ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VIII сар

Балын төрөл:

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал

БУРИАД ХОНИН ЗАЖЛУУР

Латин нэр: *Linaria buriatica* Turcz.

Англи нэр: toadflax



УРГАМЛЫН ШИНЖ:

8-20 см өндөр. Баг цэцгийн гол тэнхлэг, цоморлог цэцгийн шилбэ өтгөн сэгсгэр энгийн ба булчирхайт үсэрхэг. Цоморлогийн салбанцар 5-6 мм урт. шугаман юлдэрхүү. Иш өндиймөл. Утсархаг шулуун навчтай, бөөн цацаг ба баг цэцэгтэй.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин: Хээржүү хажуу элс, элсэн хажуу, гол, нуурын эргийн элс хайрганд ургана.


Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 38 хоног.

Балын төрөл: Зөгийн аж ахуйн үнэлгээ-Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал



БЯЦХАН НАВЧИТ ХАРГАНА

Латин нэр: *Caragana microphylla* Lam.

Англи нэр: Littleleaf Peashrub



УРГАМЛЫН ШИНЖ:

40-100 см өндөр сөөг. Мөчир бараан саарлаас хар ногоон, найлзуур нүцгэн юмуу үсэрхэг. Навчныдагавар өртөслөг, 1.5-5мм Навчисөдлөг, нийлмэл навчинцар 5-10 хос. Навчинцрын илтэс тонгоруу, өндгөрхүү, 3-10 мм урт нүцгэн юмуу үсэрхэг, мохоогоос тайранхай оройтой. Навчны бариул болон гол тэнхлэг унамтгай. Цэцэг ганц нэгээрээ. Цоморлог хоолойрхуу-хонхон, 0,9-1.2 см нүцгэн юмуу үсэрхэг. Дэлбэ 2.5 см орчим урт. Далбаа өргөн өндгөрхүү, богинохон шилбэтэй; сэлүүр шилбийн хамт илтэсний уртын ½ орчим урт, чихэнцэр үл мэдэгдэм жижигхэн. Үрэвч ихэвчлэн нүцгэн. Буурцаг шугамандуу, 4-5 см урт 4-5 мм өргөн.

Амьлралын хэлбэр: Олон наст сөөг ургамал
Ургах орчин: Элсэрхэг хээр, хээржүү чулуурхаг, хайргархаг хажуу, сондуул элс, хад чулуу асганд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал



ГАЛУУН ГИЧГЭНЭ

Латин нэр: *Potentilla anserina* L.

Англи нэр: Silverweed



УРГАМЛЫН ШИНЖ:

Махлаг үндэстэй, навчис богинохон, бариултай, зааглагдсан өдлөг, 10-15 см урт доод гадаргуу нь мөнгөлөг цагаан, торгомсог үслэгтэй. Навчинцар 4-10 хос, гонзгойвтор-юлдэрхүү, гүн шүдэрхэг, 0.5-3 см урт, 3-10 мм өргөн. Тэдгээрийн завсар дахь жижиг навчинцар 5-7 мм урт. Цэцэг шар, дэлбэ торгомсог үстэй, цоморлигоосоо 1.2-2 дахин урт.

Амьдралын хэлбэр: Олон аст өвслөг ургамал

Ургах орчин: Эргийн чийглэг, марзлаг нуга, гол, нуур, булгийн эрэг, намгархаг нуга, зам дагуу ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 62 хоног

Балын төрөл: Олон зүйлийн Балан нөөц-0.001 г

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн



ГОЁМСОГ ХУВИЛАНГИ

Латин нэр: *Pedicularis venusta* Bge.
Англи нэр: beautiful lousewort

УРГАМЛЫН ШИНЖ:

10-40 см өндөр. Дэлбийн доод уруул дуулгаасаа бараг тал хувь нь богино, нүцгэн, цоморлог үзүүртээ бараг 1/3 цуулбар, 8-10 мм урт, дэлбэ 20-25 мм урт.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин: Өндөр уулсын бүслүүр хүртэлх чийглэг, намгархаг, марзлаг, татмын болон эргийн нуга, голын эрэг, голын ой, булаг орчмын марзлаг нугад ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Балын төрөл: Зөгийн аж ахуйн үнэлгээ-Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал

ГОО УЛААГАНА

Латин нэр: *Ribes pulchellum* Turcz.

Англи нэр: Beautiful Currant

УРГАМЛЫН ШИНЖ:

Найлзуур зөвхөн үндээ хос өргөстэй, 2.5 м хүртэл өндөр. Навчис нь өргөн өндгөрхүү, захаараа шүдэрхэг салбантай. Баг цэцэг нь 8-20 цэцэгтэй, цэцгийн дагавар навч нарийн юлдэрхүү. Цомирлигийн хоолой аягархуухэлбэртэй, ногоондуу юмуу ягаан, дэлбийн хэлтэс цагаан, цайвар шар. Жимс бөөрөнхий хэлбэртэй, улаан өнгөтэй.

Амьдралын хэлбэр: Олон наст сөөг ургамал

Ургах орчин: Уулын хажуу энгэр, хад асанд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн

ДАГУУР ТАРВАГАН ШИЙР

Латин нэр: *Thermopsis dahurica* Czefr.

Англи нэр: Lanceleaf thermopsis



УРГАМЛЫН ШИНЖ:

50-100 см өндөр. Иш богино болон урт налчгар юм уу сэрэвгэр үсээр хучигдсан, маш ховор тохиолдолд үсгүй байдаг. Навчинцар 32-50 мм урт, 9-18 мм өргөн, гонзгой-өндгөрхүү голдуу үзүүрээрээ доош эргэдэг. Буурцаг 50-60мм урт 9-10мм өргөн.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг буурцагтан

Ургах орчин: Уулын хээрийн, хээрийн бүслүүрт хээржүү чулуурхаг, хайргархаг хажуу, гол, булаг, нуурын эрэг, хужир марцтай хээрийн нуга жалга судagt ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VIII-IX сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 31 хоног.

Балын төрөл: Олон зүйлийн Тоосны нөөц- 1.720 г, балан нөөц-0.028 г.

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал

ДАГУУР ХАТНЫ ЦЭЦЭГ

Латин нэр: *Cymbaria dahurica* L.

Англи нэр:



УРГАМЛЫН ШИНЖ:

5-15 см өндөр иш эгц босоо юм уу өндиймөл налчгар өтгөн үслэгээр бүрхэгдсэн саарал өнгөтэй. Навч эсрэг суусан байрлалтай, шугаман юлдэрхүү хэлбэртэй, 1.5-3 см урт, 2-5мм өргөн, хурц оройтой. Цэцэг буруу бүтэцтэй, шар өнгөтэй, 4-5 см урт. Навчтай адилхан 2 дагавар навчтай. Дэлбийн хоолой хонхорхуу, 2 уруултай, дээд уруулын хоёр салбан мохоо өндгөрхүү бөгөөд төвгөр, доод уруул 3 салбантай. Дохиур 4, амсар толгойрхуу. Жимс өндгөрхүү хэлбэртэй, 8-10 мм урт.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин: Хуурай болон хялганат хээр, уул толгодын үйрмэг чулуут болон чулуурхаг хажуу, хормой, заримдаа цөлөрхөг хээр, хад асганд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 17 хоног.


Балын төрөл: Зөгийн аж ахуйн үнэлгээ-Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал



ЖИНХЭНЭ ӨРӨМТҮҮЛ

Латин нэр: *Galium verum* L.
Англи нэр: lady's bedstraw



УРГАМЛЫН ШИНЖ:

80-100 см өндөр бүдүүн салаархаг үндэслэг иштэй. Иш нэг юм уу хэд хэдээрээ, ихэд салаархаг, дөрвөн талтай, нүцгэн юм уу зайдмал үеүдээрээ үсэрхэг, навчирхаг. Навч шугамархуу, доод гадаргуу руугаа шамирсан захтай, 18-20 мм урт 0.5-1 мм өргөн, гөлгөр, богино бариултай, 6-12-аараа тойруулга үүсгэн байрладаг. Цэцгүүд хошоод юм уу гурвантаа салаалсан шилбэн дээр олноороо сууж, оройн өтгөн залаа баг цэцэг үүсгэнэ. Дэлбэ тод шар, голчоороо 3 мм. Үр жимс нүцгэн, гөлгөр.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс
Ургах орчин: Шинэсэн ой, тэдгээрийн зах, ойн, татмын, хээрийн нуга, хялганат хээр, хээржүү хажуу, сөөг дунд, хад асга, нурагт ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI сар

Цэцэглэж дуусах хугацаа: VIII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 61 хоног.

Балын төрөл: Зөгийн аж ахуйн үнэлгээ- Тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал



ИМТ ГИЧГЭНЭ

Латин нэр: *Potentilla bifurca* L.

Англи нэр: Glabrous forked-leaf cinquefoil



УРГАМЛЫН ШИНЖ:

2-25 см өндөр, үндэслэг иштэй, ишний уг хатуурч модожсон. Иш тахир, дэлхээ юмуу хэвтээ, ёзоороосоо эхлэн мөчирлөдөг. Бүх навчис ишин дээрээ байрладаг, навчинцар 5-7 хос, гонзгойвтор, зууван, шаантгархуу бөгөөд үзүүртээ гүнзгий оньтой. Иш навчны бариул, цэцгийн шилбэ сэгсгэр үсэрхэг. Цэцэг шар, цөөн цэцэгт сийрэг баг цэцэг үүсгэдэг.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал

Ургах орчин: Уулын болон цөлөрхөг хээрийн марзлаг нуга, үйрмэг чулуут болон чулуурхаг хажуу, горхийн эргээр ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI


Цэцэглэж дуусах хугацаа: VII

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 62 хоног.

Балын төрөл: Олон зүйлийн Балан нөөц-0.015 г

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн



ИХ ШҮҮДЭРГЭНЭ

Латин нэр: *Chelidonium majus* L.

Англи нэр: Greater celandine



УРГАМЛЫН ШИНЖ:

Иш 80 см хүртэл өндөр, эгц босоо, навчирхаг, дээд хэсгээрээ мөчирлөг, нүцгэн юмуу үет сэрэвгэр үсэрхэг. Навч бариултай, дээд хэсгийнх суумал, тэдгээрийн илтэс 20 см хүртэл урт, 10 см хүртэл өргөн, дээд талдаа ногоон, доод талдаа саарал өнгөтэй. Цэцгүүд 2.5 см голчтой, тод шар, оройн шүхрэрхүү багцэцэгт нэгддэг. Цоморлог 6-8 мм урт, дугариг унатамхай. Дэлбийн хэлтэс 10-12 мм урт, эсрэг өндгөрхүү юмуу бараг дугариг. Дохиур олуулаа. Гэрцэг шулуун шугамархуу, 2-5 см урт, 2-3 мм өргөн.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал

Ургах орчин: Шинэсэн ой, хусан төгөл, голын эргийн сөөгөн шугуй, хад чулууны сүүдэрсэг суурь, нураг, ам хавцлын оёорт ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 61 хоног

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Тоост-амтат шүүст ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн



ИШГҮЙ ГИЧГЭНЭ

Латин нэр: *Potentilla acaulis* L.
Англи нэр: Cinquefoil



ТАНИХ ШИНЖ:

Үндэс орчмын навчнаасаа илүүгүй 5 см хүртэл өндөр, 1-3 цэцгэн иштэй. Сийрэг дэгнүүлтэй, ишгүй, навчис олон бөгөөд бууралдуу хилэнлэг, ургамлын бусад хэсгүүдтэй ижил цацраг маягийн үслэгээр өвч хучигдмал. Навчис үрчлээс хуниастай, ирмэгээрээ мохоо шүдэрхэг. Цэцэг шар, 10-17 см голчтой.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал

Ургах орчин: Харгана-хялганат, хялгана-шарилжит хээр, хээржүү хажуу, уулын хээр, хад чулуу, сул элсэнд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI сар


Цэцэглэж дуусах хугацаа: VI-VII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 36 хоног

Балын төрөл: Олон зүйлийн Балан нөөц-0.001 г

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн



ЛЕНИЙН ШАР ДЭМЭГ

Латин нэр: *Alyssum lenense* Adams.

Англи нэр: Sweet alyssum



УРГАМЛЫН ШИНЖ:

Иш 4-20 см өндөр, олноороо, эгц босоо юмуу уг орчимдоо өндиймөл, өтгөн навчирхаг. Навч шугаман-уртавтар юмуу юлдэрхүү, шовх оройтой, суумал, 5-20 мм урт, 1-3 мм өргөн. Цэцгүүд шар өнгөтэй, богино цацаг баг цэцэг бүрдүүлдэг ба цэцэглэх явцад 2-5 см хүртэл уртасдаг. Дэлбийн хэлтэс 4.5-6 мм урт, өргөнтонгоруу өндгөрхүү хэлбэртэй, оройдоо үл мэдэг оньтой. Гэрцгэнэ 4-7 мм урт, 3-5 мм өргөн, уртавтар-зууван, хааяа дугариг, оройдоо оньтой, нүцгэн юмуу жижиг одорхог үслэгээр өтгөн бүрхэгдсэн. Үүртээ 2 хааяа 1 үртэй.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал

Ургах орчин: Хээрийн чулуурхаг юмуу хад чулуутай хажуу, нураг, элсээрхэг хээрт ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн



МАРАЛ НАВЧИТ ГИЧГЭНЭ

Латин нэр: *Potentilla tanacetifolia* Willd.ex Schlecht.

Англи нэр: Tansyleaf Cinquefoil

УРГАМЛЫН ШИНЖ:

Иш нь 10-50 см өндөр, навчис том, урт бариултай, илтэс 3-15 см урт, өдлөг хэрчигдсэн, 3-6 (9) хос навчинцартай, навчинцар 10-35 мм урт, уртавтар, эллипсэрхүү юмуу уртавтар юлдэрхүү хэлбэртэй, хурц том шүдлэгтэй. Үндэслэг иштэй, сууриараа их салаалсан. Цэцэг шар, 1-1.5 см голчтой, цацгархуу залаа баг цэцэг үүсгэдэг.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал

Ургах орчин: Зүр өвст болон хялганат, харган-хялганат, элдэв өвс үетэнт, уулын хайрга чулуутай хажуу, хээрийн сөөгөн ширэнгэнд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VIII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 40 хоног.

Балын төрөл: Олон зүйлийн Балан нөөц-0.024 г.

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн

МОНГОЛ ХУНЧИР

Латин нэр: *Astragalus mongolicus* Bunge.

Англи нэр: Milkvetch



УРГМАЛЫН ШИНЖ:

Голлосон үндэстэй 30-60 см өндөр ургамал. Навчис дээд тал нүцгэн, доод тал нь сийрэг үслэгтэй, гонзгойвтор-зууван дугуй, зузаавтар, 10 мм урт, 2.5 мм өргөн, 10-18 хос навчинцартай. Цэцэг шар юмуу шаргал сийрэг баг цэцэгтэй, үрэвч болон буурцаг нь тэгш бус хэмтэй урт нарийн шилбэн дээр оршино. Цэцгийн дагавар навч 2-3 мм урт, бараг цэцгийн шилбэтэй тэнцүү. Цоморлиг 8-9 мм урт, хоолойрхуу-хонхон, шүд нь 2-3 мм урт, хоолойноос 3 дахин богино. Дэлбэ 14-18 мм урт. Буурцаг 9-14 мм урт, уртавтар өндгөрхүү, арьслаг үсгүй.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал

Ургах орчин: Элс, элсэрхэг хээр, хайргархаг дэнж, сайрын элстэй ёроол, чулуурхаг нураг, хад чулуу, сөөгөн ширэнгэ, шинсэн ойн захаар ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн



НАРИЙН НАВЧИТ ТАРНА

Латин нэр: *Polygonum angustifolium* Pall.

Англи нэр: Knotweed

УРГАМЛЫН ШИНЖ:

25-50 см хүртэл өндөр ургадаг салаархаг иштэй ургамал. Навч 2-4 см урт, 0.5-4 мм өргөн, нүцгэн, шугамархуу, гэдрэг эргэсэн захтай. Шадар эрхтэн тавчилсан бүтэцтэй. Шаргал өнгөтэй, олон жижиг цэцгүүд сийрэг, залаа баг цэцэг үүсгэдэг. Жимс самранцар, 2 мм урт, гурвалжин, хар өнгөтэй.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал

Ургах орчин: Уул толгодын хээржүү болон нугархаг бэл, хайргархаг хажуу дагаж ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн

НАРИЙН НАВЧИТ ХАРГАНА

Латин нэр: *Caragana stenophylla* Pojark.

Англи нэр: Narrowleaf Peashrub



УРГАМЛЫН ШИНЖ:

80 см хүртэл өндөр сөөг. Холтос сааралдуу ногоон, хааяа шаравтар хүрэн, юмуу хар хүрэн. Навчны дагавар өргөсөрхүү, 4-7 мм. Навчис дэвүүрэрхүү, 4 навчинцартай. Навчны бариул урт найлзуур дээр хагдардаггүй үлддэг, богино найлзуур дээрх нь унадаг. Навчинцрын илтэс шугаман юлдэрхүүгээс шугамархуу, 4-11 мм урт, 0.75-1.5мм өргөн хоёр талдаа ногооноос сааралдуу ногоон. Цэцэг ганц нэгээрээ. Цоморлиг хонхорхуу-хоолой, 4-6 мм. Дэлбэ шар, гэхдээ далбаа нь дунд хэсэгтээ улаан шаргалдуу хүрэн; далбаа дугуйгаас өргөн тонгоруу өндгөрхүү, 0.8-1.8 см урт, өргөн ба богинохон шилбэтэй; сэлүүр шилбийн хамт илтэсний уртын ½ тэнцүү, чихэнцэр мохоо. Үрэвч нүцгэн. Буурцаг бортгорхуу, 2-2.5 см.

Амьдралын хэлбэр: Олон наст, сөөг ургамал
Ургах орчин: Элсэрхэг хээр уул, толгодын чулуурхаг, шавранцар хажуугаар ургана.
Цэцэглэж эхлэх хугацаа: VI сар
Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар
Балын төрөл: Олон зүйлийн
Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал
Таримал/Байгалийн: Байгалийн ургамал



НҮЦГЭН НАМУУ, ХУРГАН ЗАСАА

Латин нэр: *Papaver nudicaule* L.

Англи нэр: Iceland poppy



УРГАМЛЫН ШИНЖ:

Иш (20) 25-50 (60) см өндөр, ганц нэгээрээ юмуу хааяа хэд хэдээрээ нийлж, сийрэг дэгнүүл үүсгэн ургадаг. Навч бүдүүн бариултай, дээд хэсгээрээ өргөссөн, илтэс 2-12 см урт, 1.5-6 см өргөн, өдлөг цуулбар, тэдгээрийн салбангууд уртавтар юмуу юлдэн, хааяа шугаман хэлбэртэй, бүтэн захтай эсвэл цөөн шүдлэгтэй, ширүүн юмуу ширүүвтэр өтгөн бүрхэгдсэн. Цэцгийн шилбэ шулуун, бат бөх, ширүүн үсэрхэг. Цэцэг шар өнгөтэй, ихэвчлэн том, 4-7 см голчтой. Дохиур олон, Цэцэглэж үест үрэвчээсээ урт болдог.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал

Ургах орчин: Хээрийн нуга, хялганат хээр, чулуурхаг хажуу, хад, чулуу, голын эрэг, хайрга, эргийн нуга, сөөг дунд ургана.


Цэцэглэж эхлэх хугацаа: VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VIII сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн



ОРОС ЦАРГАС

Латин нэр: *Medicago ruthenica* L. Ldb.

Англи нэр: Russian wildrye-alfalfa



УРГАМЛЫН ШИНЖ:

10-25 см өндөр. Газраар зулсан өндиймөл иштэй, нэлмэгэр бутаар ургадаг. Хуурайсаг чийгсүү. Гурвалсан нийлмэл навчтай. Навчинцар жижиг шүдэрхэг захтай, нарийн гонзгой юлдэрхүүгээс шугаман юлдэрхүү. Цэцгийн шилбэ 2-5 мм урт. Дэлбэ 5-6 мм урт шаравтар ба хүрэн ягаан өнгө хослосон алаг. Буурцаг гонзгой зууван, хавтгай, 8-10 мм урт 3-4,5 мм өргөн, тэдгээр тус бүр 1-4 үртэй.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин: Голын эргийн харгиа, эргийн нугад ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VII-VIII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VIII-IX сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал



СУДАЛТ ХУВИЛАНГА

Латин нэр: *Pedicularis striata* Pall.

Англи нэр: Lousewort



УРГАМЛЫН ШИНЖ:

Салаалсан босоо үндэстэй, буржгар үслэг, 15-80 см өндөр, бат цэх иштэй. Навч нь бариултай, өдлөн цуурч урт шугаман юлдэрхүү сегмент үүсгэх ба захаараа шүдлэг авч ишний оройн навч бүтэн захтай. Цэцгүүд нийлж урт өтгөн баг цэцэг үүсгэсэн байдаг. Цомирлог нь 10 мм орчим урт, нүцгэн сарьслаг-өвслөг, тэдгээрийн шүд нь хоолойноосоо 2 дахин богино. Дэлбээ нь шар бөгөөд улаан судалтай, 25-32 мм урт, доод уруул нь дуулгатайгаа зэрэгцээ, богино гурван далбант салбантай, урт шилбэтэй, дуулга нь тахир.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин: Хээрийн үйрмэг чулуут болон чулуурхаг хажуу, элсэрхэг хээр, хээрийн сөөг дунд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн үнэлгээ- Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал

ШИВҮҮРТ УЛААГАНА, ТЭХИЙН ШЭЭГ

Латин нэр: *Ribes diacanthum* Pall.

Англи нэр: Siberian currant



УРГАМЛЫН ШИНЖ:

1-2 м өндөртэй. Найлзуур үл ялиг ирмэгтэй, нүцгэн; навчны суурьт 3-5 мм хос шивүүртэй, заримдаа зайдмал нь өргөслөг. Нахиа хүрэндүү, өндгөрхүү, 3-5 мм, нүцгэн, хурц оройтой. Навчис тонгоруу өндгөрхүүгээс ромбон-тонгоруу өндгөрхүү, 1.5-3.5 см урт, нүцгэн, шаантган суурьтай; 3 салбантай, гүн хөрөөн шүдлэг захтай, мохоо юмуу хурц оройтой. Цацаг баг цэцэгбогинохон, олон цэцэгтэй нүцгэн. Цэцэг жижигхэн, цайвар шар. Жимсгэнэ улаан, бөөрөнхий, 5 мм голчтой, нүцгэн, исгэлэн амттай.

Амьдралын хэлбэр: Олон наст сөөг ургамал

Ургах орчин: Чулуурхаг хээржүү хажуу, хад асга, нураг, голын хөндийн элсэнд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI сар


Цэцэглэж дуусах хугацаа: VII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 18 хоног

Балын төрөл: Олон зүйлийн Балан нөөц-38.42 г

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн



ҮЛДЭН МОГОЙН ИДЭЭ

Латин нэр: *Sedum aizoon* L.
Англи нэр: Aizoon Stonecrop



УРГАМЛЫН ШИНЖ:

Иш 15-50 см өндөр, нүцгэн, бэржгэрдүү, цөөнөөрөө гардаг бат бөх, эгц босоо, зөвхөн багцэцэг орчимдоо мөчирлөдөг. Бүдүүн богиноссон үндэслэг иштэй, олон наст өвслөг ургамал. Навч 2-6 (8) см урт, 5-12 (20) мм өргөн, цувраа байрлалтай, юлдэрхүү хэлбэртэй, хөрөөн шүдлэг захтай. Баг цэцэг нягт бамбайрхуу. Цоморлог 2-4 мм урт, өргөн гурвалжин юмуу сууриасаа уртассан өндгөрхүү хэлбэртэй. Дэлбэ 5-6 (8) мм урт, юлдэрхүү, алтлаг шар өнгөтэй, цоморлогоос 2-3 дахин урт. Дохиур дэлбийн хэлтсээс богино, 1-2 мм урт шилбэтэй. Үр жимс уртавтар-өндгөрхүү хэлбэртэй, 1-2 мм урт шонтонтой.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал
Ургах орчин: Ой болон ойт хээрийн бүслүүрт уулын чулуурхаг хажуу, хад асга, нураг, голын эргийн элс, хайрганд ургана.


Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 34 хоног

Балын төрөл: Олон зүйлийн Балан нөөц- 0.395 г
Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн



ҮХЭР ТАРНА, ДЭРВЭЭН ТАРНА, УСАН ШИМЭЛДЭГ

Латин нэр: *Polygonum divaricatum* L.

Англи нэр: Finnish



УРГАМЛЫН ШИНЖ:

1 м өндөртэй, сууриасаа эхлээд их салаалсан, ацан салаа мөчиртэй, бөөрөнхий бөөн бут үүсгэдэг ургамал. Навчис нарийн юмуу шугаман юлдэрхүү, хоёр үзүүрээдээ жигд нарийссан, ишний адил, нүцгэн эсвэл судал дагуу тачир үсэрхэг. Урт цацагаас бүрдэх том, сийрэг залаа баг цэцэгтэй, самранцар том, 4-7 мм урт.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал

Ургах орчин: Хээр тал, хээржүү хажууд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VII-сар

Цэцэглэж дуусах хугацаа: VIII- сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 23 хоног

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн



ХАВИСХАНА НАВЧИТ БЭРИШ

Латин нэр: *Bupleurum scorzonerifolium* Willd.

Англи нэр: Bupleurum, hong-chai-hu

УРГАМЛЫН ШИНЖ:

25-30 см өндөр Ишний навчис өндгөн юлдэрхүү эсвэл юлдэрхүү, сууриадаа ялимгүй сунгуу. Шүхрийн шилбэ 10-15 ороолтонцорын навчинцар, 7-12 шар ногоон, шүхрэнцэрээсээ нэлээд урт, заримдаа түүнтэй бараг тэнцүү.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин: Уулын хажуу хээр, ойн зах, ойн хуурайвтар нугад ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VII-VIII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VIII-IX сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 41 хоног.

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал

ХАДНЫ СЭРХЛИГ

Латин нэр: *Patrinia rupestris* (Pall.) Dufur
Англи нэр: Siberian Valerian

УРГАМЛЫН ШИНЖ:

Иш бүхэлдээ үсэрхэг, 3-4 хос цуулбар өдлөг навчистай; цоморлог бараг үл мэдэгдэм жижиг, дэлбэ суурьтаа дөнгөж мэдэгдэх төдийн цүлхэнтэй.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг
Ургах орчин: Ойт хээр, хээрийн бүсэд уулын чулуурхаг хажуу, байц, ам хавцалд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI- сар
Цэцэглэж дуусах хугацаа: VII сар
Балын төрөл: Олон зүйлийн
Таримал/Байгалийн: Байгалийн

ХОЁР ИШТ БЭРИШ

Латин нэр: *Vupleurum bicaule* Helm.

Англи нэр: Vupleurum



УРГАМЛЫН ШИНЖ:

5-30 см өндөр, Нягт дэгнүүл үүсгэн ургадаг, голлосон үндэстэй. Иш ихэвчлэн 2-оороо, сууриасаа өндиймөл. Үндэс орчмын навч ишнийхээс урт бөгөөд нарийхан. Навчис ширүүн, Нарийн шөвгөрхүү, 3-12 урт, 1-2 мм өргөн, 3-5 судалтай. Шүхэр жижиг, 1-5 см голчтой, 10-20 цэцэгтэй ба харилцан адилгүй урттай 5-12 шилбэтэй. Цэцэг шаргал өнгөтэй. Үр жимс зууван өндгөрхүү, 2.5-3.5 мм урт 1.5-2 мм өргөн.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин: Уулын хайргархаг ба чулуурхаг хажуу, нам уулс, дов толгодын хээржүү ба цөлөрхөг хажуу, тачир өвст хээрийн нуга тэгш тал байц хадны ёроолд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VII-VIII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VIII-IX сар

Балын төрөл: Олон зүйлийн

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал



ХУРЦ САЛБАНТ ХОНИН ЗАЖЛУУР

Латин нэр: *Linaria acutiloba* Fisch. ex Reichb.

Англи нэр: common toadflax, yellow toadflax, or butter-and-eggs



УРГАМЛЫН ШИНЖ:

Иш 15-50 см өндөр, энгийн юм уу салаалсан, навчирхаг. Ургамал бүхэлдээ нүцгэн. Навчис 3-5 см урт, 0.5-1.5 см өргөн, юлдэрхүү юм уу юлдэн шугамархуу, зэгэл, саарал өнгөтэй. Цэцгүүд түрүүрхүү баг цэцэг бүрдүүлдэг ба баг цэцгийн иш болон цэцгийн хөл нүцгэн. Цэцгийн дагавар юлдэн, цэцгийн шилбэтэй тэнцүү юм уу дөнгөж урт. Цоморлог нүцгэн, 3 мм орчим урт, уртавар-тонгоруу-өндгөн, шовх салбангуудад гүн цуулбарлагдсан. Дэлбэ шар, доод уруулдаа тод улбар шар өнгийн толботой, 12-15 мм урт. Годой конус хэлбэртэй, бага зэрэг тахир ба 10-11 мм урт. Хонхорцог өндгөн юм уу бараг бөмбөлөгөн, 6-8 мм урт, 5-6 мм өргөн нүцгэн. Үр голдоо товруутай.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин: Хээрийн ба нугархаг хажуу, голын эргийн болон ойн нуга, сийрэг шинэсэн ой, нарсан ой тэдгээрийн зах, хадны суурь, нураг юм уу эргийн хэвгий, хонхор, ам, хөндийн оёор, сайр, тариалангийн талбай, атар газар, хагалсан газарт ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 41 хоног.

Балын төрөл: Олон зүйлийн

Балан нөөц- 0.001 г.

Зөгийн аж ахуйн үнэлгээ- Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал

ШАР ГОНТОГ

Латин нэр: *Erysimum flavum subsp. altaicus*
(С.А. Mey) Polozh.

Англи нэр: Yellow wallflower



ТАНИХ ШИНЖ:

Иш 10- 60 (100) см өндөр, ихэнхдээ ганц нэгээрээ, эгц босоо, мөчирлөг биш. Навчис уртавтар-шугамархуу, сууриараа сунгуу нарийссан, бүтэн захтай, үндэс орчмын болон ишний доод хэсгийнх заримдаа шүдэрхэг, гол төлөв доош махийсан оройтой. Цоморлогийн навчинцар 7-9 (10) мм урт, гадна талын хос нь нилээд өргөн, угтаа мэдэгдэхүйц цүлхгэр. Дэлбийн хэлтэс цайвар шар, 12-18 (20) мм урт, өргөн, эгц босоо, ихэнхдээ бага зэрэг дугариг. Гэрцэг жимс харьцангуй өргөн, эгц босоо, ихэнхдээ бага зэрэг нумарсан. Үр боловсрох орны багана 1-2 мм урт. Үр 1.5-2 мм урт, хүрэн өнгөтэй, уртавтар гонзгой хэлбэртэй.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал

Ургах орчин: Хээр, сайрга чулуу ба хадархаг хажуу энгэр, хээр тал, эргийн хайрганд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 34 хоног

Балын төрөл: Олон зүйлийн Тоосны нөөц- 0.023 г

Таримал/Байгалийн: Байгалийн

ШАР ХУВИЛАНГА

Латин нэр: *Pedicularis flava* Pall.

Англи нэр: Lousewort



УРГАМЛЫН ШИНЖ:

Салаа бүхий, голлосон бат босоо үндэстэй. Навчлаг, арзгар үслэг, 10-30 см өндөр энгийн иштэй. Навч нь өдлөг цуулбар, шугамархуу-юлдэн хэлбэрийн том далбант сегмент үүсгэсэн байх ба тэдгээрийн далбан нь гурвалжин шовх, хэрчигдэж мөгөөрсөрхүү шүдтэй. Ишний угийн болон доод хэсгийн навчис урт бөгөөд баг цэцгийн доод, заримдаа дунд хэсэгт хүрдэг. Ишний дээд хэсгийн навчис богино илтэс нь энгийн бараг хошоод-өдлөг цуулбар, хол шүдлэг, бариулынхаа хоёр тал руу бууж тогтсон байдаг. Шар өнгийн цэцгүүд боргоцойрхуу нягт баг цэцэг үүсгэсэн. Цомирлиг нь 15 мм урт, сарьслаг, эсгийрхүү саглагар үслэг. Дэлбээ нь 28-32 мм урт, хоолой нь дуулгатайгаа тэнцүү, бөгөөд дуулга нь тахир богино.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин: Хээр тал, хээрийн үйрмэг чулуут болон чулуурхаг хажуу, хад асга, цохио, нуга, голын эргийн марзлаг нуга, хайрганд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар


Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 18 хоног.

Балын төрөл: Олон зүйлийн

Балан нөөц- 0.006 г. Зөгийн аж ахуйн үнэлгээ- Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал



ШАР ЦАРГАС

Латин нэр: *Medicago falcata* L.

Англи нэр: Yellow alfalfa



УРГАМЛЫН ШИНЖ:

40-120 см өндөр. Иш эгц босоо эсвэл өндиймөл, конус, салаалсан. Навч юлдэрхүү, сууриараа сум маягийн хэлбэртэй, орой шовх. Баг цэцэг 10-20 мм, 6-20 цэцэгтэй, дэлбэ шар, 6-9 мм, урт тонгоруу өндгөрхүү. Үрэвч шугаман, үрт нахиа 2-5. Буурцаг 10-15, 2.5-3.5 мм. Үр бор өндгөрхүү-зууван.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг
Ургах орчин: Хээрийн нуга, хажуу, ойн хуурай зах элсэрхүү юм уу шаварлаг хөрс, эргийн элс хайрганд.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI сар


Цэцэглэж дуусах хугацаа: VIII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 52 хоног.

Балын төрөл: Олон зүйлийн Тоосны нөөц- 13.84 г, балан нөөц- 0.368-1.237 г.

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал



ЭМИЙН БАГВААХАЙ

Латин нэр: *Taraxacum officinale* Wigg.

Англи нэр: Common dandelion



УРГАМЛЫН ШИНЖ:

10-25 см урт 1.5-5 см өргөн хагалбар юм уу бараг бүтэн навчистай, түүний далбан нь шүдлэг хааяа бүтэн. Сагсны доор шилбээ дагасан эсгийрхүү цайвар үслэгтэй. Ороолтын навчинцар 13-20 мм урт, нүцгэн бөгөөд үзүүртээ эвэр бараг байхгүй. Цэцэг тод шар өнгөтэй. Үрэнцэр цайвар бор юм уу боровтор өнгөтэй, 3-4 мм урт, шонтонойгоо 7-12 мм урт. Эмийн ач холбогдолтой болон балт ургамал.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин: Ой ба татмын нуга, ойн зах, хус ба нарсан төгөл, гол горхи, цэнгэг нуурын эрэг, түүнчлэн зам, суурин газрын нүцгэн газар ба гудамж, атаржсан ба тариалангийн талбайн захаар ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал



ЭГЭЛ БУРЖГАР

Латин нэр: *Thalictrum simplex* L.

Англи нэр: Small meadow rue

УРГАМЛЫН ШИНЖ:

50-100 см өндөртэй. Иш энгийн эсвэл салаалсан, гөлгөр. Навч эгц шулуун ойролцоогоор бариултайгаа 20 см, илтэс хос өдлөг. Баг цэцэг шүхэр 9-30 см. Цэцгийн шилбэ 1-7 мм. Цоморлиг 4, эрт унадаг, цагаан, өргөн зууван, 2.2 мм. Дохиур 15 мм, шилбэ хялгасан, тоосовч өргөн зууван гонзгой 2 мм, үзүүр шовх. Үр боловсрох орон 3-6, амсар өргөн гурвалжин. Үр өндгөрхүү эсвэл өргөн зууван 2 мм, 8 судалтай.

Ургах орчин: Голын эргийн нуга, сөөгөн шугуй, эргийн ой, шинэсэн ой, хусан ой, ойн зах болон нуга, нугархаг хажууд ургана.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал

Цэцэглэж эхлэх хугацаа: VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 23 хоног.

Балын төрөл: Олон зүйлийн Тоосны нөөц- 0.021 г, балан нөөц- 0.014 г.

Зөгийн аж ахуйн ангилал: Тоост-амтат шүүст ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн



АЛТАЙН СОГСООТ

Латин нэр: *Heterorhappus altaicus* (Willd.) Novopokr

Англи нэр:



УРГАМЛЫН ШИНЖ:

5-50 см өндөр. Иш хэд хэд. Эгц, иш босоо юм уу өндиймөл ширүүн үзүүртээ дээш тахир, налсан үслэгтэй. Ороолт навчинцар, зөвхөн дунд хэсэгтээ ногоон, захаараа цагаан хальслаг эмжээртэй. Бүх үрэнцэрийн цомцог адилхан. Хэл цэцэг цайвар хөх юм уу хөх ягаан өнгөтэй.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин: Хээр, хээржүү нуга, сайргархаг ба чулуурхаг хажуу, хад, сайрын хөвөө ба оёор, сул бэхлэгдсэн элс, бэл хайрганд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Балын төрөл: Балан нөөц- 0.001-0.035 г.

Зөгийн аж ахуйн үнэлгээ- Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал

АЦАН ЦАХИЛДАГ

Латин нэр: *Iris dichotoma* Pall.
Англи нэр: Vesper iris



УРГАМЛЫН ШИНЖ:

Иш 50-100 см өндөр, ацан салаалалттай. Навчис нь сэлмэрхүү, нэг хавтгайд байрласан, гүн ногоон захаараа цайвардуу, 40 см хүртэл урт, 3.5 см хүртэл өргөнтэй. Цэцэг нил ягаан өнгөтэй, шадар эрхтэн 6, хоёр хүрээ үүсгэж байрлана. Цэцэг хайрсархуу 2 навчны дунд байрлана. Үр жимс хонгорцог бөгөөд хавтсаараа ханзарна.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал

Ургах орчин: Элсэрхэг хээр, голын эргийн элсэнд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VIII сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн



БАР ЦООХОР ЦАХИЛДАГ

Латин нэр: *Iris tigridia Bunge ex Ledeb.*

Англи нэр: Tiger iris



УРГАМЛЫН ШИНЖ:

30 см өндөртэй ургадаг. Хар ногоон эсвэл саарал ногоон өнгийн навчтай бөгөөд эдгээр нь 5-30 см (2-12 см) урт, 1.5-6 мм өргөнтэй ургадаг. Цэцэглэлтийн үеэр навч нь 5-13 см урт, өргөн нь 1.5-2 мм байна. Навч нь босоо, шугаман эсвэл бага зэрэг муруй хэлбэртэй ба хурц үзүүртэй байдаг. Жижиг оврын үндэслэг иштэй байдаг. Эдгээр нь бор, шар эсвэл цагаан, шилэн юм. Үндэслэг ишний дор олон тооны махлаг, хоёрдогч үндэс байдаг тэдгээр нь 3-4 мм өргөн. Үндэслэг ишний орой дээр өтгөн, бор, эсвэл хар хүрэн, сүүлчийн навчны шилэн хөвөн. Жижиг булцуутай. Нарийхан иштэй, 3-4 см урт. Иш нь шар-ногоон, салст бүрхэвчтэй (цэцгийн нахиа навчтай) байдаг. Цэцэг нь 3.5-5 см диаметртэй ягаан өнгийн сүүдэртэй, хар хөх, цэнхэр өнгөтэй бөгөөд бараан толботой байдаг.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал

Ургах орчин: Хад чулуурхаг, хайргатай, хуурай толгод дээр (эсвэл налуу), тал хээр, ойн захаар ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: IV-V сар

Цэцэглэж дуусах хугацаа: V сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 30 хоног

Балын төрөл: Олон зүйлийн

Ургамлын балан нөөц: 0.016 г

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн

БУЛЦУУТ ТУЙПЛАНЦАР

Латин нэр: *Phlomis tuberosa* L.
Англи нэр: tuberous Jerusalem sage

УРГАМЛЫН ШИНЖ:

40-150 см өндөр. Урт нарийхан утсархаг үндэстэй, үндсэндээ булцуутай. Иш эгц босоо ба дээд хэсгээрээ мөчирлөн салаалсан. Нүцгэн юм уу баг цэцэг орчимд үл мэдэг үсэрхэг, ягаавтар хүрэн өнгөтэй. Үндэс орчмын навч гурвалжин хэлбэртэй, 13-15 урт, 10-12 см өргөн, сууриараа гүн зүрхэрхүү, гүдэн шүдлэг захтай, илтсээс нэг дахин урт бариултай, бариул энгийн юм уу үет үслэгээр бүрхэгдсэн. Ишний навчис уртаватар гурвалжин хэлбэртэй, суурь хэсэгтээ гүн биш зүрхэрхүү, урт бариултай, бариул энгийн юм уу үет үслэгтэй. Цэцгүүд алслагдсан тойруулга баг цэцэг бүрдүүлдэг. Дагавар навч 10-12 мм урт, шугаман зүүрхүү хэлбэртэй, цоморлогтоо тэнцүү юм уу урт, урт сэрэвгэр олон үет үслэгээр бүрхэгдсэн. Цоморлог хоолойрхог-хонхорхуу, 8-10мм урт нүцгэн эсвэл энгийн сийрэг үслэгтэй, тал дугуй шүдлэгтэй, шүдлэгүүдийн хооронд урт багц үслэгтэй, шүдлэг дунд хэсгээрээ хотойсон ба хотгор хэсгээс өргөслөг хурц сортой. Дэлбэ ягаан эсвэл цайвар ягаан өнгөтэй, цоморлогоос 1.5-2 дахин урт гадна талаараа үсэрхэг. Самранцар өндгөрхүү-гурвалжин хэлбэртэй, оройгоороо өтгөн үслэгтэй.

Амьдралын хэлбэр:

Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин:

Хээр ба уулын нугархаг хажуу, хуурай хөндийн нуга, ойн цоорхой, ан хавцалд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа:

VI сар

Цэцэглэж дуусах хугацаа:

VII-VIII сар

Балын төрөл:

Олон зүйлийн

Тоосны нөөц- 0.227 г,

балан нөөц- 0.121-0.799 г.


Зөгийн аж ахуйн үнэлгээ-

Амтат шүүст-тоост

ургамал.

Таримал/Байгалийн:

Байгалийн ургамал



БУРГАС НАВЧИТ БАНЗДОО

Латин нэр: *Saussurea salicifolia* (L.) DC.

Англи нэр: Saw-wort

УРГАМЛЫН ШИНЖ:

Иш 20-40 (60) см өндөртэй. Голлосон бүдүүн үндэстэй, ихэнхидээ бут үүсгэн ургадаг. Навчис шугаман-юлдэн юм уу шугаман, шамирсан бүтэн ирмэгтэй, 2-8 мм өргөн. Сагсан дахь цэцгүүд хоолойрхуу, ягаан өнгийн бамбай баг цэцэгтэй.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг

Ургах орчин: Үетэн- алаг өвст хээр, хээрийн ширэгжсэн ба чулуурхаг хажуу, элсэрхэг хээрт ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VII- сар

Цэцэглэж дуусах хугацаа: VIII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 34 хоног.

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн

БУРГАС НАВЧИТ ТАВИЛГАНА

Латин нэр: *Spiraea salicifolia* L.

Англи нэр: Willow-leaf meadowsweet, Bridewort Spirea



УРГМАЛЫН ШИНЖ:

2 м хүртэл өндөр, эгц босоо ургадаг. Өтгөн шигүү найлзууртай, шаргал хүрэн холтостой, үл мэдэг ирмэгтэй, залуудаа үсэрхэг, сүүлдээ нүцгэрдэг. Нахиа өндгөрхүүгээс гонзгой өндгөрхүү, хэд хэдэн хүрэн хайрстай, хурц оройтой. Навчис зууван юмуу өргөн юлдэрхүү, 4-8 см урт, 1.5-3 см өргөн, нүцгэн, гол судал тод, хурц хөрөөн шүдлэг, шаантган суурьтай, шовх оройтой. Баг цэцэг өтгөн, олон цэцэгтэй залаа 5-10 см урт, урт навчирхаг найлзуур дээр үүсдэг. Цоморлигийн наавчинцар гадагш дэрэвгэр. Дэлбийн хэлтэс ягаан, өндгөрхүү; гипанти хонхорхуу. Хэтэвч (үр жимс) эгц босоо, нүцгэн.

Амьдралын хэлбэр: Олон наст сөөг ургамал

Ургах орчин: Ойн болон өндөр уулын бүслүүрт, голын эрэг, шинэсэн болон шиэнс-хусан ой, хусан төгөл, эргийн ой, сөөгөн шугуй, чулуурхаг асгарагт ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VIII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 32 хоног

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн



БҮНГИЙН ЯРГУЙ

Латин нэр: *Pulsatilla bungeana* C. A. Mey.

Англи нэр: Pasque flower



УРГАМЛЫН ШИНЖ:

5-25 см өндөр, нягт налархай үсэрхэг. Бүх навч сууриас гарсан 3 эсвэл 4-лсөн сарвуулаг. Цэцэг хонхорхуу хоолой маягийн, цоморлиг дэлбээнээс богино, сууриараа нийлсэн, ногоон. Дэлбэ ягаан, нил ягаавтар хөх, урт налархай үсэрхэг, сууриараа нийлсэн, үр боловсрох орон олон. Хавар эрт цэцэглэдэг ургамал.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал

Ургах орчин: Уулын алаг өвст хээр, хад асга, чулуутай хээрлэг энгэр, уулын хээр, хуурай хайрганд ургана.


Цэцэглэж эхлэх хугацаа: V сар

Цэцэглэж дуусах хугацаа: VI сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Тоост- амтат шүүст ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн



ВЛАСОВЫН ШИМТЭГЛЭЙ

Латин нэр: *Geranium wlassovianum* Fish.

Англи нэр: cranesbill



УРГАМЛЫН ШИНЖ:

20-65 см өндөр, мөчирлөг дээд хэсгээр тархай үсэрхэг, доошоо нүцгэн. Навч урт тархай үслэг бүхий бариултай, навчны илтэс 3-7 см голчтой, бөөрөрхүү дугариг, 2 талдаа богино налчгар үсэрхэг доод гадаргуу цайвардуу ба ишний доод хэсгийн навчис 5-7 дээд хэсгийнх 3 салбанд цуулбар, салбангууд өргөн гонзгой, бараг ромборхуу, дээд хагас нь гуравчилсан цуулбар юм уу шүдлэг хэрчигдмэл. Цэцгийн шилбэ 5-7 см урт, богино, энгийн сэрвэгэр үслэгээр өтгөн бүрхэгдсэн цэцэглэсний дараа үр жимсний үр жимсний хамт дээшээ эгцэрдэг. Цоморлогийн навчинцар уртавтар 3-5 судалтай богино үзүүртэй богино налчгар үслэгээр бүрхэгдсэн, заримдаа урт ширүүн үслэгтэй холимог үсэрхэг. Дэлбийн хэлтэс (12) 15-20 мм урт, цайвар хөх ягаан өнгөтэй, бараавтар судалтай, дугариг оройтой, шаантагархуу суурьтай. Дохиурын шилбэ суурь луугаа аажим өргөссөн, доод хагастаа урт сормослигтой.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин: Голын эргийн чийглэг, намгархаг нуга, дэгнүүл, сондуулт нуга, чийглэг шинэсэн ой, холимог ой, тэдгээрийн зах, голын эргийн бургасан шугуйд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 45 хоног.

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал



ГОВИЙН ГАНГА

Латин нэр: *Thymus gobicus* Tschern.

Англи нэр: Thyme's gobi



УРГАМЛЫН ШИНЖ:

Иш дэлхмэл, цэцэглэх мөчир нягт үсэрхэг, баг цэцгийн дор арай илүү өтгөн. Ишний ба дагавар навч уртассан-юлдэн хэлбэртэй, 10-12мм урт, 2-3 мм өргөн, доод талдаа олон эст урт үслэгээр сийрэг бүрхэгдсэн, бариул нь захаараа өтгөн сормослигтой. Хөх ягаан юм уу ягаан өнгийн цэцгүүд толгойрхуу багцэцэг бүрдүүлнэ. Цоморлог 4-4.5мм урт, өтгөн, үсэрхэг, доодуруулын шүдлэгүүд захаараа өтгөн сормостой. Дэлбэ сарнайн ягаан өнгөтэй, ойролцоогоор 7мм урт.

Амьдралын хэлбэр: Олон наст сөөглөг алаг өвс

Ургах орчин: Хад нуранги асга, чулуурхаг хээржүү хажуу, цөлөрхөг хээр, голын хайргархаг эрэг, суумал элсэнд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 33 хоног.

Балын төрөл: Олон зүйлийн

Тоосны нөөц-0.577 г, балан нөөц-0.282 г.

Зөгийн аж ахуйн үнэлгээ- Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал



ГОО ЮЛД

Латин нэр: *Goniolimon speciosum* (L.) Boiss
Англи нэр: Dwarf Statice

УРГАМЛЫН ШИНЖ:

Иш нь 10-30 см өндөр, 1-2 ширхэг, сэрэвгэр богино үслэгтэй, үзүүр хэсэгтээ салаа. Үндэс бүдүүн. Үндэс орчмын навч хатуу, саарал, тонгоруу-өндгөн юм уу зууван дугуй, 2-4 (8/ см өргөн, 3-8 см урт. Цэцэгт иш гөлгөр, сууриадаа бөөрөнхий, эгц босоо. Түрүүнцэр 1.5 - 2.5 см урт, 1.1-1.9 см өргөн, цэцэглэх ишний салаа мөчрийн үзүүрт толгойрхуу, тэр нь цаашдаа бамбархуу баг цэцэгт нэгдэнэ. Цоморлог сарьслаг 7-8 мм урт, далбанцар нь жижиг, мохоо, тэдгээрийн хооронд завсрын жижиг шүдэнцэр оршино.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин: Ойт хээр, хээр, цөлийн хайргат хээр, чулуурхаг хажуу, байц хадны ёроолд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Тоост-амтат шүүст ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал



НАРИЙН НАВЧИТ ЗҮРХЭН ЦЭЦЭГ

Латин нэр: *Polygala tenuifolia* Willd

Англи нэр: Common milkwort



УРГАМЛЫН ШИНЖ:

10-25 см өндөр, нарийн, нүцгэн юм уу ялимгүй үсэрхэг. Үндэс модожсон. Ишний уг орчмын навчис юлдэн бусад нь утасхархуу, 1.5-4 см урт, 0.5-2 (2.5) мм өргөн, нүцгэн шахуу. Цэцэг хөх юм уу цайвардуу нил ягаан, заримдаа цагаан, сийрэг цэцэг бvхий хажуугийн цацаг баг цэцэг үүсгэдэг, 2-8 см урт. Цэцгийн дагавар маш жижигхэн (ойролцоо 1.5 мм урт) эрт унамтгай. Цоморлог 5-6 мм урт. Завь 7 мм урт, үзүүртээ нимгэн цацагтай. Дээд талын дэлбэн 5-6 мм урт, сэлүүрүүдтэйгээ тэнцүү ба завинаасаа ялимгүй богино. Хонхорцог 4-5 мм урт, дугуйвтар тонгоруу өндгөн хэлбэртэй.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин: Уул толгодын эгц хажуу, чулуурхаг ба хайргархаг хээр, элсэрхэг хөрсөнд ургана.


Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал



НАРИЙН НАВЧИТ ХӨВӨНТ

Латин нэр: *Chamaenerion angustifolium* L.

Англи нэр: fireweed

УРГАМЛЫН ШИНЖ:

Навчис гонзгойватор юм уу шугаман юлдэрхүү, шовх үзүүртэй, дээд тал өтгөн ногоон доод тал саарал тод ялгарах хажуугийн судалтай.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин: Голын эргийн хайрга, шинэсэн ой, хусан ой ойн зах ойн цоорхой шатсан газар, ойн нуга, нугархаг хажууд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар


Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 44 хоног.

Балын төрөл: Олон зүйлийн Тоосны нөөц- 0.593 г, балан нөөц- 0.081 г.

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал



НУГЫН ШИМТЭГЛЭЙ

Латин нэр: *Geranium pratense* L.
Англи нэр: Meadow cranesbill



УРГАМЛЫН ШИНЖ:

Иш нь 30-80 см өндөр Үндэс орчмын навч долоон шовгор дөрвөлжиндүү-өндгөрхүү хэсэгт гүн хуваагдсан тэдгээр нь юлдэрхүү салбанцарт өдлөг хэрчигдмэл. Үндэс орчмын ба ишний доод хэсгийн навчис урт үслэг бүхий бариултай. Цэцгийн шилбэ булчирхайт үсэрхэг, хааяа налчгар үслэгээр өтгөн бүрхэгдсэн ба цэцэглэх үе хүртэл гудаймал, цэцэглэлтийн үед эгц босоо, жимслэх үест доош нумардаг.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин: Шинэсэн ой, хусан төгөл, ойн зах ба нуга, сөөгөн шугуйд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар


Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 42 хоног.

Балын төрөл: Олон зүйлийн, Тоосны нөөц- 0.436 г, балан нөөц- 0.031 г.

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал



ӨРГӨСТ НОХОЙН ХОШУУ

Латин нэр: *Rosa acicularis* Lindl.

Англи нэр: Prickly Rose



УРГМАЛЫН ШИНЖ:

1.5-2 м хүртэл өндөр, өргөс шивүүр ихтэй. Навчинцар 5-7, гонзгой-өндгөрхүү, 1.5-2.5 см урт, 1-3.5 см өргөн, өвөр талд нь нүцгэн, ар талдаа үсэрхэг төдийгүй цэг мэт олон шүүсэвчтэй. Цэцэг 3-6 см голчтой хурц ягаан эсвэл улаавтар голдуу ганц нэгээрээ, хааяа 2-3-аараа байрладаг. Дэлбийн хэлтэс зүрхэрхүү. Жимс нь 2-3 см урт, 1-1.3 см өргөн, гонзгой-өндгөрхүү, хоёр талаараа шувтан, улаан унжгар.

Амьдралын хэлбэр: Олон наст сөөг ургамал

Ургах орчин: Ой болон өндөр уулын бүслүүрт шинэсэн ой ба нарсан ой, хусан төгөл, тэдгээрийн зах, эргийн сөөгөн дунд, эргийн ой, хад, асга, нураг, чулуун дунд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI сар


Цэцэглэж дуусах хугацаа: VIII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 32 хоног

Балын төрөл: Олон зүйлийн тоосны нөөц- 2.011 г

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн



СИБИРЬ ГҮЙЛС

Латин нэр: *Armeniaca sibirica* (L.) Lam


Англи нэр: Siberian Apricot



УРГАМЛЫН ШИНЖ:

1-2 м өндөртэй. Бараан саарал холтостой. Мөчир их саравгар, найлзуур сааралдуу хүрнээс улаавтар хүрэн, залуу найлзуур сийрэг үсэрхэг, сүүлдээ нүцгэрдэг. Навчны бариул 2-3.5 см урт. Навчис өндгөрхүүгээс дугаригдуу, 3-6 см урт, 2.5-4.5 см өргөн, хоёр талдаа нүцгэн, дугуйрснаас зүрхэрхүү суурьтай, мохоодуу жижиг хөрөө шүдлэг захтай, урт хурц оройтой. Цэцэг ганц нэгээрээ, навчлахын өмнө дэлгэрдэг, 1.5-2.5 см голчтой. Цоморлигийн навчинцар гонзгой зуван, Цэцэглэх үед гадагш эргэдэг. Дэлбэ цагаан, ягаан судалтай, дүгэрэгдүүгээс урвуу өндгөрхүү. Яст жимс шар юмуу, улаан шаргал, хавчгар бөөрөнхий, 1.5-2.5 см урт, үсэрхэг; мезокарп 2.5-3 мм зузаан, хуурай, нягт, гашуун, эндокарпаас амархан салдаг. Үр гашуун.

Амьдралын хэлбэр: Олон наст сөөг ургамал
Ургах орчин: Хотгор хөндийн хажуу, хээрийн сөөгөн шугуй, хээрийн хад цохиот болон чулуурхаг хажуу, хад асганд ургана.
Цэцэглэж эхлэх хугацаа: V-VI сар
Цэцэглэж дуусах хугацаа: VIII-IX сар
Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 16 хоног
Балын төрөл: Олон зүйлийн Тоосы нөөц- 1.015 г
Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал
Таримал/Байгалийн: Байгалийн



СИБИРЬ ЗҮРХЭН ЦЭЦЭГ

Латин нэр: *Polygala sibirica* L.
Англи нэр: Common milkwort



УРГАМЛЫН ШИНЖ:

10-20 см өндөр, Навчис юлдэрхүү юм уу зуувгар 0.8-2 см урт 3-7 мм өргөн. Иш нь бахим тачир налархй үсэрхэг. Цэцгийн шилбэ, цоморлигийн навчинцар, дэлбэ судал дагуу тачир үсэрхэг. Далбаа 6-7.5 мм урт, завь 8 мм урт.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин: Нугархаг болон хээржүү хажуу, хээрийн нуга, ойн зах, нарсан ойд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 50 хоног.

Балын төрөл: Олон зүйлийн

Балан нөөц- 0.002 г.

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал

СИБИРЬ ХОТЙ

Латин нэр: *Leonurus sibiricus* L.
Англи нэр: Siberian motherwort



УРГАМЛЫН ШИНЖ:

30-80 см өндөр. Навчис 3/4 хүртлээ гурвалсан цуулбар, салбангууд нь гүн өдлөг цуулбар бөгөөд шугаман-юлдэрхүү юм уу шугамархуу хэлбэрийн салбанцартай. Цоморлог үл мэдэг 2 уруултай, түүний доод 2 шүд эргэж нугараагүй боловч дээд 3-саа урт. Дэлбэ 15-20 мм урт, шулуун, хоолой нь дээд хэсгээрээ өргөсөөгүй, дээд уруул нь дуулгархуу ба нэлээд богино, шулуухан доод уруултай. Цэцэг цайвар ягаан өнгөтэй.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин: Хээрийн чулуурхаг хажуу, хуурайсаг ам хавцлын оёор хөвөө, нураг, таримлын талбай ба суурин газар ургана.


Цэцэглэж эхлэх хугацаа: VI сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн үнэлгээ- Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал



СИБИРЬ ШИМТЭГЛЭЙ

Латин нэр: *Geranium sibiricum* L.

Англи нэр: Siberian geranium



УРГАМЛЫН ШИНЖ:

Нарийхан үндэстэй. Цэцэг ганц нэгээр байрладаг дэлбийн хэлтэс жижигхэн, 0,5 см-ээс богино, цайвар ягаан.

Амьдралын хэлбэр: 2 наст өвслөг алаг өвс
Ургах орчин: Голын эрэг дагуух гүехэн газар, бургасан шугуй, ногооны талбай, орон байрны ойролцоо, новширхуу газар ургадаг.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал



ТҮМЭН НАВЧИНЦАРТ ОРТУУЗ

Латин нэр: *Oxytropis myriophylla* (Pall.) DC

Англи нэр: Small Leaved Locoweed

УРГАМЛЫН ШИНЖ:

Зэвхий өнгийн үслэгтэй, ишгүй, дэгнүүлт олон наст өвслөг ургамал, 5-10 мм урт 1 мм өргөн нарийн шугаман хэлбэрийн 6-8 аараа багцалж тойруулга үүсгэсэн жигд байрласан навчистай. Сөрөвгөр үслэг шулуун, нарийхан шилбэ бүхий цэцэгтэй. 20 мм голчтой цэцэг нь нил ягаан буюу хааяа цагаан өнгөтэй байдаг. Цоморлог нь 8-12 мм голчтой, цэцгийн завь 1,5-2 мм урт шонтоной, үслэг гадаргуутай. 15 мм урттай гонзгой юлдэрхүү хэлбэртэй үслэг буурцагтай.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг буурцагтан

Ургах орчин: Хайргатай хээр газрын энгэр, нугат хээр, хөрстэй газрууд, нарсан ой, ойн хуурай захаар ургадаг.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII сар

Балын төрөл:

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал

УДВАЛ НАВЧИТ ТАВИЛГАНА

Латин нэр: *Spiraea aquilegifolia* Pall.

Англи нэр: Meadowsweet



УРГАХ ШИНЖ:

1 метр хүртэл өндөр. Иш мөчир бор, өтгөн үсэрхэг, нахиа (гөлөг) өндгөрхүү, жижиг, цөөн боровтор сорвитой, нүцгэн. Навчны бариул 1-2 мм, илтэс тэгш бус, Цэцэглэж ишин дээрх навчнууд өндгөрхүү, ишний навчнууд сааралдуу ногоон, дэвүүр маягийн 7-10 мм, эгц, орой шовх. Дэлбэ цагаан, 2-3 мм, дохиур 20, ҮБО-ны багана дохиураас богино.

Амьдралын хэлбэр: Олон наст сөөг ургамал

Ургах орчин: Өндөр уулын бүслүүрийн доод хэсэг хүртэл нуга хээржүү хажуу, татмын нуга, намганцар хайрганд ургана.

Цэцэглэж үрлэх хугацаа: V сар

Цэцэглэж дуусах хугацаа: VI-VII сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн



УРАЛЫН ЧИХЭР ӨВС

Латин нэр: *Glycyrrhiza uralensis*

Англи нэр: Ural licorice



УРГАМЛЫН ШИНЖ:

40-100 см өндөр. Хажуугийн салаа бүхий, газрын гүн рүү цэх доош орсон, бүдүүн гол үндэс ба хөрсөн дор хөндлөн хавж ургадаг үндэслэг иштэй. Гонзгойвтор-өндгөрхүү, наалдамхай-шүүсэвлэг, шовх, 4-6 хос навчинцраас тогтсон сондгой өдлөг нийлмэл навчтай. Цэцэгт иш навчнаасаа богино. Далбаа, завь, сэлүүрээс тогтсон цайвар нил дэлбээ бүхий эрвээхий хэлбэрийн том цэцгүүд богино, өтгөн, цацаг баг цэцэг үүсгэдэг. Буурцаг нь 4 см урт, 5 мм орчим өргөн, гонзгойвтор, хавчиг их тахир хөндлөн долгионлог, гадна талдаа шүүсэвлэг, ноолүүрлаг, гол төлөв өргөслөг, үр бөөр хэлбэртэй.

Амьдралын хэлбэр: Олон наст, өвслөг

Ургах орчин: Чийглэг марзлаг нуга, мараалаг элс, элсэрхэг дов, жижиг нуурын хүрээ, хотгор хотос газрын зах, дэрс, гол горхийн дагуу, алаг авс, үетэнт хээр гол нуурын хөндий, дов сондуулд ургана.


Цэцэглэж эхлэх хугацаа: VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: IX сар

Балын төрөл:

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал



УТСАН ОРТУУЗ

Латин нэр: *Oxytropis filiformis* Pall
Англи нэр: Locoweed



УРГАМЛЫН ШИНЖ:

Жижиг дэгнүүл үүсгэн ургадаг, каудексээр хөгждөг, ишгүй ургамал. Дагавар навч бариулын тэн хагас хүртэл нийлж ургасан ба уртавтар өндгөрхүү хэлбэртэй, налчгар цагаан үслэгээр бүрхэгдсэн. Навчны тэнхлэг иш ба бариул налчгар цагаан үслэгээр хучигдсан, 12-15 хос навчинцартай. Навчинцрууд богино юлдэрхүү хэлбэртэй, шовх оройтой, 4-7 мм урт, 1-2 мм өргөн 2 талдаа налчгар цагаан үсэрхэг. Цэцгийн шилбэ навчнаас 2 дахин урт нарийхан махигар, хар үслэг холилдсон налчгар цагаан үслэгээр бүрхэгдсэн. Цэцгүүд зуувгардуу цацаг баг цэцэг бүрдүүлдэг. Цоморлог 2,5-3 мм урт хонхорхуу, цагаан ба хар налчгар үсэрхэг, шүдлэгүүд гурвалжин, цоморлогийн хоолойноос 3-4 дахин богино. Дэлбэ хөх-ягаан өнгөтэй, далбаа дугариг, 6-7 мм урт. Завь 1,5-2 мм урт шонтонтой. Буурцаг зууван, 6-8 мм урт хатуу сарьслаг, нэг үүрт, цагаан ба хар үсэрхэг.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг буурцагтан

Ургах орчин: Уулын хөндий хайргажуу болон чулуурхаг хажуу, хээржүү эргийн хайрга, хад чулуунд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Балын төрөл: Олон зүйлийн
Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал

УЛБАЛЗУУР МОГОЙН ИДЭЭ

Латин нэр: *Sedum telephium* L.

Англи нэр: Live Forever



УРГАМЛЫН ШИНЖ:

Үндэслэг иш богинохон, болцгор, булцуурхуу, моджоогүй. Иш нь 30-60 см өндөр, навчис цувраа, гонзгой өндгөрхүү, 2-7 см урт, 1-3 см өргөн, хар ногоон өнгөтэй. Баг цэцэг шигүү бамбай. Цэцэг тавчилсан бүтэцтэй, дэлбээ зуувгар юлдэрхүү 5-6 мм орчим урт, улбар ягаан юмуу улаан.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал

Ургах орчин: Ой болон өндөр уулын бүслүүрийн чулуу, чийглэг хадтай энгэр, эргийн мөлгөр хайрга, халилт нуга, ойн зах, сөөгөн ширэнгэ, ногооны болон усалгаатай тариан талбайд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 26 хоног

Балын төрөл: Олон зүйлийн Тоосны нөөц- 0.410 г, балан нөөц- 0.013 г

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн



ҮНЭГЭН СҮҮЛХЭЙ ТАРНА

Латин нэр: *Polygonum alopecuroides* Turcz. ex Besser.

Англи нэр: Slender bistort



УРГАМЛЫН ШИНЖ:

Богиносмол найлзуур хийгээд 50-70 см өндөр цэцэглэгч иш өгдөг бүдүүн тахиралдсан үндэслэг иштэй. Ишэндээ 8 үетэй, нарийн юлдэрхүү гонзгойвтор 5-7 см өргөн, угруугаа нарийсмал, захаараа нугалармал, доод тал нь нүцгэн, гол судал нь гүргэр, ишний дунд хэсгийн навч шугамархуу, оройн навч шөвгөрхүү ягаавтар туяатай. Жижэг цагаан цэцгүүд ойр байрлаж нарийн бортгорхуу бул хэлбэрийн нягт түрүү баг цэцэг үүсгэсэн.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг

Ургах орчин: Өндөр уулын бүслүүрийн доод хэсэг хүртэлх уулын чулуурхаг ба өвслөг хажуу, голын эрэг, эргийн нуга, бургасан шугуй, хайрга, шинэсэн ой, тэдгээрийн зах, ойн нугад ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII сар

Балын төрөл: Олон зүйлийн Холимог

Таримал/Байгалийн: Байгалийн



ХИАЗТАЙ ХОНГОРЗАЛАА

Латин нэр: *Serratula marginata* Tausch.

Англи нэр: saw-wort

УРГАМЛЫН ШИНЖ:

Навч хөх саарал, урт бариултай, ирмэгээрээ богино сормослог. Ороолт навчинцар захаараа ба дээд хэсэгтээ хүрэн, хурц юм уу 1-2 мм богино өргөстэй. Сагс ганц нэгээрээ.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг

Ургах орчин: Ойн бүслүүр ба өндөр уулын доод хэсэгт шинэсэн ой, тэдгээрийн чөлөө, ойн нуга ба нугажуу хажуу, эрэг орчмын хайрга, хаданд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VII- сар

Цэцэглэж дуусах хугацаа: VIII сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн

ХИЖЭЭЛ СОНГИНО, МАНГИР

Латин нэршил: *Allium senescens* L.

Англи нэр: Aging Chive



УРГАМЛЫН ШИНЖ:

Иш 20-60 см өндөр, сонгинолог иштэй. Сонгинолог булцуу 1-2 см голчтой, бараан саарал хальсан бүрхүүлтэй. Навчис 5-8 ширхэг, 3-6 (10) мм өргөн, хавтгай ишнээсээ 2 дахин богино, шугаман хэлбэртэй. Цэцэг цайвар ягаанаас гүн ягаан хүртэл өнгөтэй. Ишний оройд тал бөмбөлөг хэлбэрийн өтгөн шүхэр баг цэцэг үүсгэдэг, цэцгийн шилбэ нь шадар эрхтнээсээ 2-3 дахин урт. Дохиур шадар эрхтнээсээ 1.5 дахин урт, суурь руугаа өргөн, ирмэгээрээ шүдлэггүй. Үр боловсрох орны багана шадар эрхтнээсээ урт. Үр жимс 3 талт хонхорцог

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал

Ургах орчин: Хээрийн нуга, уулын хажуу, голын эргийн болон хээрийн сөөгөн шугуй, эргийн нугад ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VIII сар


Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 42 хоног

Балын төрөл: Олон зүйлийн

Тоосны нөөц- 0.1 г, **балан нөөц-** 0.064, 0.029 г.

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн



ХОНГОР ЗУЛЛИГ ХОНГОРЗАЛАА

Латин нэр: *Serratula centauroides* L.

Англи нэр: Plumeless saw-wort



УРГАМЛЫН ШИНЖ:

Иш 15-80 см өндөр, ширүүн үсэрхэг ургамал. Босоо үндэслэг иштэй, бүх навч нимгэн, сарьслаг гүн өдлөг цуулбар. Навчны сегмент бүтэн ирмэгтэй юм уу зайтай ба жигд бус шүдлэгтэй. Сагсан дахь цэцгүүд хэлэрхүү, ягаан, улаан ягаан өнгийн хэд хэдээрээ иш салааны үзүүрт байрлана.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг

Ургах орчин: Хээрт, хээржүү хажуу, нуранга асга, сайрын элсэрхэг хайргархаг оёор, нимгэн элс, элсэрхэг хээрт ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VII- сар

Цэцэглэж дуусах хугацаа: VIII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 52 хоног.

Балын төрөл: Олон зүйлийн Тоосны нөөц- 0.136 г, балан нөөц- 0.131-0.089 г.

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн



ХӨДӨӨГИЙН БАТРАШ

Латин нэр: *Mentha arvensis* L.

Англи нэр: Wild mint



УРГАМЛЫН ШИНЖ:

Иш 15-50 (100) см өндөр, өндиймөл юм уу хэвтээ, хааяа эгц босоо. Навч өндгөрхүү, уртавтар-өндгөрхүүгээс уртавтар-юлдэн хүртэл хэлбэртэй, 2-7 см урт, 1-3.5 см өргөн, шовх оройтой, хөрөөн шүдлэг захтай, дугуй юм уу хэлбэртэй, шовх оройтой, сормослог ба үсэрхэг, цэцгийн шилбэнээс урт юм уу тэнцүү. Олон тооны цэцгүүд ишний дээд хэсгийн навчны өвөрт бөмбөлгөрхүү маягийн хуурамч тойруулган баг цэцэг бүрдүүлдэг. Цоморлог хонхорхуу хэлбэртэй, 2.5 мм урт, ягаавтар өнгөтэй, үсэрхэг, завьжиндаа нүцгэн, шүдлэгүүд гурвалжин хэлбэртэй, хоолойноос 3 дахин богино, шовх үзүүртэй. Дэлбэ 3.5-5 мм урт, өргөн хоолойрхог, ягаан юм уу сарнайн-ягаан өнгөтэй, цоморлогоос 2 дахин урт юм уу цоморлогийн хоолойд нуугдмал. Дохиур дэлбэтэй тэнцүү юм уу түүний хоолойноос хэд дахин урт. Самранцар дугариг, ойролцоогоор 1 мм урт ба өргөн, оройгоороо мохоо, гөлгөр, хянгагүй.

Амьдралын хэлбэр:

Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин:

Эргийн нуга, гол нуурын чийглэг ба намгархаг эрэг, хааяа тариалангийн талбай болон зам дагуу ургадаг хөл газрын ургамал.

Цэцэглэж эхлэх хугацаа:

VI сар

Цэцэглэж дуусах хугацаа:

IX сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр:

Балын төрөл/ нэг төрлийн:

Таримал/Байгалийн:

Байгалийн ургамал



ЧӨДӨР СЭДЭРГЭНЭ ХӨДӨӨГИЙН СЭДЭРГЭНЭ

Латин нэр: *Convolvulus arvensis* L.

Англи нэр: field bindweed



УРГАМЛЫН ШИНЖ:

20-100 см Мөчирлөг, урт үндэслэг иштэй. Иш хэд хэдээрээ, ороонго юм уу хэвтээ байрлалтай. Навч 2 см хүртэл урт бариултай, сум хэлбэртэй, дунд салбан гурвалжин юм уу өндгөрхүү дугариг ба доод салбангууд гурвалжин. Цэцгүүд 1-3 аараа урт цэцгийн шилбэн дээр суудаг, шугамархуу хэлбэрийн эсрэг суусан, жижигхэн дагавар навчтай. Цоморлог 6 мм орчим урт, дэлбээс 2 дахин богино. Дэлбэ ягаан юм уу хааяа цагаан, 25-35 мм голчтой. Дохиурууд доод хэсэгтээ булчирхайлаг богино үслэгтэй.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин: Голын эргийн нуга, горхи булаг, сувгийн эрэг хөвөө, гуу жалгын хажуу, сайрын зах, үйрмэг чулуут хээржүү хажуу, дэрсэн шугуй, тариан талбай, ногооны талбайд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Балын төрөл: Олон зүйлийн

Балан нөөц- 0.044-0.57 г. Зөгийн аж ахуйн үнэлгээ- Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал



ЦАЦАГТ ҮЛД ӨВС

Латин нэр: *Orostachys fimbriata* (Turcz.) A. Berger.
Англи нэр: Duncce's Caps

УРГАМЛЫН ШИНЖ:

10-15 см өндөр өвслөг ургамал юм. Ишний навчис нь юлдэрхүү юмуу шугамархуу, 1-3 см урт, иш 10-30 см өндөр, үзүүрийн болон дэвсээ навчис зууван, үзүүртээ мөгөөрслөг цагаан хайрс шүдэрхэг, үзүүртээ өргөслөг, үндэс орчмын дэвсээ навчис хар ногоон өнгөтэй. Цэцэг улаавтар, хатахдаа хөхөрдөг мөчирлөг түрүү үүсгэнэ. Тоосовч шар, хааяа бараандуу өнгөтэй.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал

Ургах орчин: Уул толгодын хээржүү чулуурхаг, үйрмэг чулуут хажуу, хад цохио, чулуурхаг нураг, элсэрхэг хээр талд. (Turcz.) Berger

Цэцэглэж эхлэх хугацаа: VIII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VIII сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн



ЦУУЛБАР НИЛ

Латин нэр: *Viola dissecta* Ldb.
Англи нэр: Violet, Tufted Pansy

УРГАМЛЫН ШИНЖ:

Ишгүй. Бүдүүн нэмэлт үндэс бүхий богиноссон үндэслэг иштэй, 5-25 см өндөр цэцэглэх иштэй. Үндэс орчмын навчис 2-18 см урт бариултай, илтэс ерөнхийдөө зууван, дугариг юм уу дугариг бөөрөрхүү, 8-9 уртаватар юм уу шугамархуу хэлбэрийн бүтэн салбангуудад өдөлсөн юм уу сарвуулсан гүн цуулбар, богино ширүүн үслэгээр сийрэг бүрхэгдсэн эсвэл нүцгэн. Цэцгүүд 15-20 см урт цэцгийн шилбэтэй. Цоморлог 3,5-6 мм урт, түүний шүдлэгүүд уртаватар-юлдэн хэлбэртэй. Дэлбэ цайвар-нил ягаан өнгөтэй 5-7 мм годойтой, годой нь бага зэргийн махир. Хонхорцог уртаватар, бараг нүцгэн, 8-10 мм урт.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин: Ойн зах, хусан төгөл, нарсан ой, сөөгөн шугуй, сүүдэрсэг хаданд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал

ШОШЛОЙРХОГ ХОШООНГОР

Латин нэр: *Trifolium lupinaster* L.

Англи нэр: Lupine clover

УРГАМЛЫН ШИНЖ:

30-60 см өндөр. Иш энгийн эсвэл дундаас дээш хэсэгт салаалсан. Навчис 3(5)-9-р сарвуулаг цуулбар, дагавар навч бариултай. Навчинцар юлдэрхүүгээс шугаман гонзгой, том 30-50 мм урт, 5-20 мм өргөн юлдэрхүү, дунд судлаараа налчгар үсэрхэг, захаараа жижигхэн бөгөөд хурц шүдтэй. Дэлбэ ягаан хүрэн, хааяа ягаан. Буурцаг саарал бор, гонзгой, 3-9 үртэй өндгөрхүү.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг буурцагтан

Ургах орчин: Элдэв өвстэй эргийн ба ойн нуга, ойн зах ба нуга, хусан ба шинэсэн төгөл, сөөг ширэнгэ, голын эргээр ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VII-VIII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VIII-IX сар

Балын төрөл: Олон зүйлийн Тоосны нөөц- 0.249 г, балан нөөц- 0.020 г.

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал

ШҮДЛИГ СОНГИНО

Латин нэр: *Allium bidentatum*

Англи нэр: Wild Onion

УРГАМЛЫН ШИНЖ:

Иш 15-25 см өндөр, эгц босоо, шар ногоон өнгөтэй. Сонгинолог булцууны бүрхүүл хар бараан юмуу сааралдуу ширхэглэг. Тал бөмбөлөг юмуу бараг бөмбөлөг хэлбэрийн улбар ягаан шүхэр баг цэцэгтэй. Шүхэр өтгөн, тал бөөрөнхий, шадар эрхтний навчинцар 5-6 мм урт, өтгөн ягаан, дотоод дохиурын утас өндрийнхөө 2/3-3/4 хүртэл өргөн хэсэгтээ хоёр шүдлэгтэй.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал

Ургах орчин: Хуурай хээр, уулын чулуурхаг хажуу, хад чулуу, голын хайрганд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI сар

Цэцэглэж дуусах хугацаа: VIII сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн

БАГ ХОНХОН ЦЭЦЭГ

Латин нэр: *Campanula glomerata* L.

Англи нэр: Clustered Bellflower



УРГАМЛЫН ШИНЖ:

Иш 20-60 см өндөр, эгц босоо, заримдаа мөчирлэг, богино цагаан үслэгээр бүрхэгдсэн юм уу нүцгэн. Навч жижиг гүдэн шүдэрхэг, ногоон өнгөтэй, богино үсэрхэг юм уу нүцгэн. Навч жижиг гүдэн шүдэрхэг, ногоон өнгөтэй, богино үсэрхэг юм уу хааяа нүцгэн, мохоо юм уу шовх оройтой. Үндэс орчмын ба ишний доод хэсгийн навчис бариултай, тэдгээрийн илтэс уртавтар-өндгөрхүү хэлбэртэй, дээд хэсгийнх суумал, нарийхан заримдаа ишээ хагас зуусан. Баг цэцэг өврийн өтгөн ба үзүүрийн толгойрхуу хэлбэртэй ба хол хол зайтай. Цэцгүүд том, 2-4 см урт, хоолойрхуу-юулүүрэрхүү хэлбэртэй, хааяа гадна талдаа судлаа дагасан богино үсэрхэг. Цоморлог ногоон, үсэрхэг шүдлэгүүд юлдэрхүү, шовх, дэлбээс 3-4 дахин богино. Багана цухуйдаггүй.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс
Ургах орчин: Шинэсэн ой, тэдгээрийн зах, хусан төгөл, боролж, бургасан шугуй, ойн ба татмын нуга, нугархаг хажуу, ам хөндийн сүүдэрсэг оёорт ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 36 хоног.

Балын төрөл: Балан нөөц- 0.015 г.

Зөгийн аж ахуйн үнэлгээ- Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал



БАЙГАЛЬ ГҮҮН ХӨХ

Латин нэр: *Scutellaria baicalensis* Georgi.
Англи нэр: Baikal skullcap



УРГАМЛЫН ШИНЖ:

15-50 см өндөр. Бүдүүн махлаг богиноссон үндэслэг иштэй. Энгийн юм уу салаалж мөчирлөсөн эгц босоо иштэй. Иш нүцгэн юм уу хавиргаараа махир богино үсэрхэг. Навч ишин дээр өтгөн байрласан ба 1.5-4 см урт, 6-8 мм өргөн, зуван-юлдэнгээс шугамархуу-юлдэн хүртэл хэлбэртэй, маш богино (1-2 мм) бариултай юм уу бараг суумал, дугариг суурьтай, мохоо оройтой, бүтэн захтай, ирмэг нь доод гадаргуу руугаа эргэж хуйларсан, дээд гадаргуу хар ногоон өнгөтэй, нүцгэн, захаараа сормослог, доод гадаргуу цайвар ногоон өнгөтэй, гол судлаа дагасан үсэрхэг, суумал булчирхайлагтай. Цэцгүүд ишний дээд хэсгийн навчны өвөрт маш богино (2 мм) шилбээр зөвхөн нэг талдаа бэхлэгдэж, нэлээд өтгөн цацаг баг цэцэг бүрдүүлдэг. Цоморлог 3-4мм урт өтгөн үсэрхэг. Дэлбэ хөх өнгөтэй, 2-2.5 см урт. Самранцар бөмбөлөгөрхүү, жижигхэн, хар өнгөтэй, бүх гадаргуугаараа жижиг товруутай, нарийхан орооцолдсон сийрэг үслэгтэй.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс
Ургах орчин: Хээрийн бүсэд хад чулуутай хажуу, элсэрхэг газраар ургана.


Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн үнэлгээ- Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал



МОНГОЛ ДОГАР, ЯМААН ЭВЭР

Латин нэр: *Caryopteris mongolica* Bge.

Англи нэр: Blue Mist



УРГАМЛЫН ШИНЖ:

Иш 20-50 см өндөр, маш хүчтэй салаалж их мөчирлөсөн, залуу найлзуур хүрэн улаан, мөчир, навч нь тачир цагаан үсээр өвч хучигдсан саарал өнгөтэй, намхан заримдаг сөөг ургамал. Навчис чагтан байрлалтай, суумал, юлдэрхүү, хоёр үзүүрүүдээ нарийссан шувтан, 3.5-4 см урт, 5-6 мм өргөн, бүтэн ирмэгтэй. Дэлбэ 10-12 мм урт, бундуйжих үест цэнхэр байснаа сүүлдээ хөх ягаан, хөх цэнхэр өнгөтэй болдог, гадна талдаа үсэрхэг. Дэлбийн дээд уруул нь үзүүртээ дэвүүрэрхүү цацаглан цуурах бөгөөд доод уруул нь 4 жижиг салбантай. Дохиур урт шилбэтэй, дэлбэнгээсээ 10-12 мм цухуйдаг. Багана урт, үзүүртээ 2 салаа амсартай. Жимс 4 далавчтай, торлог судалтай, 4 самранцар болж задарна.

Амьдралын хэлбэр: Заримдаг сөөг.

Ургах орчин: Хээр, цөлийн уул, хярын чулуурхаг, үйрмэг чулуут хажуу, хад асга, сайрын хөвөө, элс хайрган оёор, голын харгиа, нимгэн давхраат элсэнд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VIII- сар

Цэцэглэж дуусах хугацаа: IX сар

Балын төрөл: Олон зүйлийн Зөгийн аж ахуйн үнэлгээ- Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн



НАРИЙН ЦЭЦЭГТ ХОНХЛОЙ

Латин нэр: *Adenophora stenantha* (Ldb.) Kitag.
Англи нэр: Crofton weed



УРГАМЛЫН ШИНЖ:

40-120 см өндөр. Баг цэцэг задгай саравгар, хөндлөн мөчиртэй, залаархуу юм уу өргөн цацгархуу. Дэлбэ хоолойрхуу хонхон, салбангийн дор нарийссан багана нь дэлбээсээ дээш их илүү гарсан.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин: Уулын хээржүү, нугархаг хажуу, голын эрэг, эргийн нуга, ойн зах, сөөгөн шугуйд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 21 хоног.

Балын төрөл: Балан нөөц- 0.008 г.

Зөгийн аж ахуйн үнэлгээ- Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал



НУМРАА ХУНЧИР

Латин нэр: *Astragalus adsurgens* Pall.

Англи нэр: Milkvetch

УРГМАЛЫН ШИНЖ:

20-45 (60) см өндөр ургамал. Цоморлиг 5-6 (7) мм урт, цоморлигийн шүдлэг хялгасархуу, хоолойноосоо 3-5 дахин богино. Дэлбэ хондон улаан юмуу хурц-нил ягаан өнгөтэй, 15 мм урт, далбаа 5-6 мм өргөн. Буурцаг гонзгойдуу, гурван талт бортгорхуу, бор-хүрэн үсээр хучигдсан. Үндэс ширхэглэг, ихэвчлэн хүчирхэг, уян зөөлөн.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал

Ургах орчин: Марцлаг эргийн нуга, эргийн хотгор, марц хужиртай элс хайргархаг газар, хээржүү хажуу, дов сондуултай нимгэн элс, ойн нугад ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI сар

Цэцэглэж дуусах хугацаа: VIII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 32 хоног

Балын төрөл: Олон зүйлийн Тоосны нөөц- 0.261 г, балан нөөц- 2.557 г

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн



ОЙН ДУРСГАЛЖ ЦЭЦЭГ

Латин нэр: *Myosotis sylvatica* (Ehrh.) Hoffm
Англи нэр: woodland forget-me-not

УРГАМЛЫН ШИНЖ:

5-15 см өндөр. Цэцгийн шилбэ цоморлогоосоо 1.5-2 дахин урт. Иш навчис урт, зөөлөн сэрэвгэр үсээр хучигдсан. Үндэс орчмын навчис илтэстэйгээ бараг тэнцүү бариутай. Дэлбэ цэнхэр өнгөтэй.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин: Өндөр уулын болон ойн бүслүүрийн шинэс ба холимог ой, хусан төгөл, ойн нуга, сөөгөн шугуй, ширэгжсэн асарга чулуунд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI сар


Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 35 хоног.

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн үнэлгээ- Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал



СИБИРЬ ЗИРАА

Латин нэр: *Lactuca sibirica* (L.) Benth. ex Maxim
Англи нэр: Prickly lettuce



УРГАМЛЫН ШИНЖ:

50-100 см өндөр. Ишний навч голдуу ишээ зуусан дугараг суурьтай юлдэн, урт шовх үзүүртээ, бүтэн ирмэгтэй, хааяа гүн шүдлэг юм уу салбанлаг. Ороолт 9-13 мм урт. Иш ягаавтар улаан, эгц босоо, үзүүрээрээ салаалсан, нүцгэн. Навч нимгэн, доод болон дунд навчнууд суумал, юлдэрхүү хэлбэртэй.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин: Шинэсэн ой тэдгээрийн зах, бургасан шугуй, татмын нуга, ногоон хөвдөд-гацууран ойд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-IX сар

Балын төрөл: Тоосны нөөц- 0.231 г, балан нөөц- 0.692 г.

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал



ТАГИЙН ГОЛ ГЭСЭР

Латин нэр: *Aster alpinus* L.

Англи нэр: Alpine aster



УРГАМЛЫН ШИНЖ:

15-25 см салаархаг бүдүүн үндэслэг иштэй. Иш хэд хэдээрээ юм уу олноороо, эгц босоо, салаалаагүй цөөн навчистай, богино ширүүн үслэгээр бүрхэгдсэн. Үндэс орчмын навчис дэвсээ, уртавтар тонгоруу-юлдэнгээс тонгоруу-өндгөрхүү хүртэл хэлбэртэй, суурь луугаа нарийссаар бариулд шилжсэн, бүтэн захтай, цайвардуу ногоон өнгөтэй. Сагс 3-5 см голчтой, ганц нэгээрээ байрладаг. Ороолт хагас бөмбөлөгөн хэлбэртэй, түүний навчинцар 2 эгнээгээр байрладаг, 5-8 мм урт. Сагсны захын хуурамч цэцгүүд хөх, ягаавтар, заримдаа цагаан голын цэцгүүд шар өнгөтэй, сийрэг үсэрхэг. Үр үсэрхэг, уртавтар тонгоруу.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин: Ой ба уулын хээр, өндөр уулын бүслүүрт шинэсэн ой, тэдгээрийн зах нугажуу, хээржүү хажуу ба хад асга чулуунд ургана.


Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 65 хоног.

Балын төрөл:

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал



ХАДНЫ БӨГТӨРГӨНӨ

Латин нэр: *Amblynotus rupestris* (Pall.) M.Pop.ex Serg.
Англи нэр: Common amblynotus



УРГАМЛЫН ШИНЖ:

Бүдүүн босоо хар үндэстэй, урт налчгар үслэгээр бүрхэгдсэн. Иш олноороо нарийхан, эгц босоо юм уу нумархуу хэлбэртэй, мөчирлөг биш. Үндэс орчмын навчис 1-2 см урт, уртавтар-хүрээрхүү хэлбэртэй, мохоо оройтой, хавтгай ба эрт хагдардаггүй. Ишний навч уртавтар-шугамархуу хэлбэртэй хазгайдуу. Цэцгүүд цацаг баг цэцэг үүсгэх ба баг цэцгийн доод хэсэгт жижиг дагавар навчинцартай. Цэцгийн шилбэ 2-10мм урт, шулуун босоо. Цоморлог 1 мм урт жимслэх үест 3 мм хүртэл уртасдаг. Дэлбэ цэнхэр өнгөтэй, 3-7 мм голчтой. Самранцар жижигхэн, 1.5-2 мм урт, уртавтар-өндгөрхүү хэлбэртэй, нуруун талдаа гүдгэр ба гялалзсан цагаан өнгөтэй.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин: Хээрийн үйрмэг чулуут болон чулуурхаг хажуу, элсэрхэг хээр, уул толгодын бэл хормой, хад чулуу, голын эргийн хайрганд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Балын төрөл: Олон зүйлийн

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал

ЦАГААЛИН ЦАХИЛДАГ

Латин нэр: *Iris lactea* Pall.

Англи нэр: White-flowered iris



УРГАМЛЫН ШИНЖ:

14-70 см урт, 3-7 мм өргөн, цайвар ногоон, угтаа хатсан навчны угларгаар хучигдмал. Хайрсан бүрхэвч навч хальслаг, нэлээд өргөн, үрлэлтийнхээ үед цаасархуу нимгэн болдог. Цэцэг 1-2, бүдэгдүү нил цэнхэр, хааяа цагаан. Шадар эрхтний хоолой маш богинохон. Шадар эрхтний гадаад хүрээний навчинцар 5-6 см урт, 1-1.5 см өргөн, түүний илтэс юлдэрхүү хэлбэртэй, хурц оройтой. Үр жимс хонгорцог, гонзгой юмуу ээрүүлэрхүү, урт шонтонтой.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал

Ургах орчин: Нуур, гол, булгийн марзлаг эрэг, хайрга, марзлаг нуга, хээрийн хотос, марзны хөвөө, дэрстэй хотгор, сайрт ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: V сар

Цэцэглэж дуусах хугацаа: VI сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн



ЦАРСАН ГҮҮН ХӨХ

Латин нэр: *Scutellaria scordifolia* Fisch exSchrank

Англи нэр: Mongolian skullcap



УРГАМЛЫН ШИНЖ:

10-30 см өндөр. Бүдүүн уртассан үндэслэг иштэй. Иш эгц босоо сууринаасаа мөчирлөг хавиргаа дагасан үслэгтэй. Навч уртавтар юлдэн, зууван юм уу уртавтар хэлбэртэй 1-3.5 см урт 3-8 мм өргөн, 2-3 мм богино бариултай, шаантгархуу суурьтай, мохоо юм уу мохоовтор оройтой, захаараа тэнцүү биш шүдэрхэг, заримдаа ирмэг нь дотогшоо эргэсэн ба ирмэгээ дагасан богино үсэрхэг. Цэцгүүд ишний дээд хэсгийн навчны өвөрт хос хосоор, ишний нэг талд байрладаг. Цоморлог 3.5-4.5мм урт, дээд хэсгээрээ хондон улаавтар ягаан өнгөтэй, богино налчгар усэрхэг ба булчирхайлаг. Дэлбэ 18-22 мм урт, бараан хөх өнгөтэй, дээд талаараа өргөссөн юүлүүрэрхүү хэлбэрийн хоолойтой, гадна ба дотор талдаа голоо дагасан булчирхайлаг үслэгтэй. Дохиур 4 ба 2 нь урт. Самранцар 1.5-2 мм урт. Бараавтар хүрэн өнгөтэй, хөхлөг маягийн товруурхаг гадаргатай.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс
Ургах орчин: Нугархаг ба хээржүү хажуу, голын эрэг, эргийн ой, сааган ширэнгэ, ойн захаар, хааяа хог ургамал байдлаар ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар


Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 65 хоног.

Балын төрөл: Олон зүйлийн

Тоосны нөөц- 0.353 г, балан нөөц- 0.013г. Зөгийн аж ахуйн үнэлгээ- Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал



УЛИАНГАР

Латин нэр: *Populus tremula* L.

Англи нэр: Aspen poplar



УРГАМЛЫН ШИНЖ:

20 м хүртэл өндөр ургадаг. Холтос саарал- ногоон, гөлгөр, гол ишний доод хэсгийн холтос хагарч цуурдаг, титэм задгай, бөөрөнхий. Найлзуур бор сааралдуу. Нахиа өндгөрхүү-бөөрөнхий, үсэрхэг, үнэргүй. Навчны бариул хавчгар, илтсэний уртаас бараг урт, илтэс дүгрэг юмуу дүгрэг-гурвалжиндуу, нүцгэн, тайрмал юмуу бүдэг зүрхэрхүү суурьтай, жигд бус хотон шүдэрхэг. Эр болон эм цэцгийн молцог 4-6 см, жимслэх үед 10 см урт болно. Хонгорцог нарийн шовгор, нүцгэн, хоёр хавтастай.

Амьдралын хэлбэр: Олон наст модлог ургамал

Ургах орчин: Ойн бүслүүрт шинэсэн ой, хусан ой, гол, нуурын эрэг, намаг, эргийн ой, ам хавцлын ёроол, голдуу дан шугуйд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: IV сар

Цэцэглэж дуусах хугацаа: V сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн

ШИВҮҮРТ ҮЛД ӨВС (ХАТГУУРТ ҮЛД ӨВС, ХӨХӨӨНИЙ АЙРАГ, ЗҮГИЙ, ЗУГАЙ, ҮД ӨВС)

Латин нэр: *Orostachys spinosa* (L.) C. A. Meyer.
Англи нэр: Spiny Pennywort



УРГАМЛЫН ШИНЖ:

10-30 см өндөртэй. Цайвардуу ногоон өнгөтэй, голлосон үндэст ургамал. Эхний жил олон тэвгэн навчтай; тэвгэн навчны илтэс гонзгой, цагаан мөгөөрслөг өргөстэй; 2 дахь жилд тэвгэн навчны дундаас гарах иш 10-30 см өндөр; Ишний навч шүүслэг, цувраа, суумал, ланцуйн, 1-2.5 см урт, 2-5 см өргөн, оройгоодоо нарийссаар мөгөөрслөг өргөстэй. Оройн өргөс 2-4 мм урттай, хурц. Ишний угийн тэвэг навч цэцэглэх үед хамт хүрэнтэн хатна. Баг цэцэг нь түрүү. Цэцгийн өнгө нь шар ногоон, цэцэгс маш богино шилбэн дээр ганц нэгээр шигдэн байрлана. Цоморлиг 3 мм урт, ногоовтор шаргал; дэлбийн хэлтэс өндгөн ланцуйн, шовгор оройтой; дохиур дэлбээнээс урт, тоосовч шар; үр гонзгой өндгөн, 1 мм орчим урт, 0.2 мм өргөн. Үр жимс нь хэвлийн заадлаараа ханзардаг хэтэвч, үрээр сайн ургадаг. Үр нь хөнгөн учраас салхиар хийсэн тархана.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал

Ургах орчин: Уулын хээржүү бүслүүрт хайргархаг ба чулуурхаг хажуу, байц цохио, эргийн хайранд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: IX сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 37 хоног

Балын төрөл: Олон зүйлийн Тоосны нөөц- 2.285 г, балан нөөц- 0.010г, 0.048г, 0.273 г

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн

ДОЛГИОТСОН ГИШҮҮНЭ

Латин нэр: *Rheum undulatum* L.

Англи нэр: Siberian rhubarb



УРГАМЛЫН ШИНЖ:

Иш 50-100 (150) см өндөртэй, голлосон үндэстэй ургамал. Үндэс орчмын навчны илтэс гурвалжин-өндгөрхүү, 10-50 см урт, ихэд долгиотсон захтай, үрчгэр, навчны дээд ба доод гадаргуу хилэнэрхүү өтгөн бүрсгэр, бариул нь илтэстэйгээ бараг чацуу, улаавтар өнгөтэй, шүүслэг. Ишний навчис арай жижиг, цөөхөн, суумал. Нарийхан урт залаа багцэцэгтэй. Жимс 8-10 мм урт, 3 талтай, өргөн зуувандуу хэлбэртэй, далавч цайвар бор өнгөтэй, үр нь өндгөрхүү, хүрэн өнгөтэй.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг

Ургах орчин: Хээрийн бүс болон уулын ой, ойт хээрийн бүслүүрт голын эргийн хайрга, эргийн ой, сөөгөн шугуй, чийглэг нуга, ам хавцал, хурдасын овоолго, бул чулуун дунд, хааяа өндөр уулын бүслүүр хүртэл ургасан байдаг.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр:

Балын төрөл/ нэг төрлийн:

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал

ЗӨӨЛӨН НАВЧИТ ҮЛД ӨВС (ХӨХӨӨНДАРС ҮЛД ӨВС)

Латин нэр: *Orostachys malacophylla* (Pall.) Fisch.

Англи нэр: Green Dunces cap



УРГАМЛЫН ШИНЖ:

Иш 10-30 см өндөр. Эхний жил олон тэвгэн навчтай (үндэс орчмын навч); навчны орой хатгуур өргөсгүй, илтэс нь гонзгой-ланцуй юмуу тонгоруу өндгөн, орой нь мохоо юмуу зөөлөн шовгор; 2 дахь жилд тэвгэн навчны дундаас гарах иш 5-10, 30-35 см өндөр; ишний навч цувраа, том, 7 мм хүртэл урт, зөөлөн шовгор оройтой, Үндэс орчмын дэвсээ навч зууван, бүтэн, оройдоо өргөсгүй, цэцэглэх үест хагдардаг. Баг цэцэг нягт, түрүүрхүү, уртассан цацаг, олон цэцэгтэй; цоморлигийн хэлтэс гонзгой, шовх оройтой, 3-4 мм урт; дэлбийн хэлтэс шар, гонзгой юмуу өндгөн, орой нь дугуй шүдлэг, 4-6 мм урт; дохиур дэлбээнээс урт, цэцэг шаргал, тоосовч шар. Үр өндгөн, жижиг.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал

Ургах орчин: Уулын хээржүү бүслүүрт хайргархаг ба чулуурхаг хажуу, байц цохио, эргийн хайранд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI- VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн

НАВТГАР ТАВАН САЛАА

Латин нэр: *Plantago depressa* Willd.

Англи нэр: Depressed plantain



УРГАМЛЫН ШИНЖ:

Голлосон үндэстэй. Навчис 2-10 см урт, 1-3.5 см өргөн, уртавтар-зууван, юлдэн хааяа зууван, 5-7 тод судалтай, бүтэн захтай юм уу доод хагастаа цөөн шүдлэгтэй, нүцгэн юм уу доод гадаргуу үсэрхэг, бариул илтэсээс 2-5 дахин богино, заримдаа түүнтэй тэнцүү. Цэцгийн сум иш 5-30 см урт, ихэвчлэн үсэрхэг. Түүрүү баг цэцэг 20 см урт доод хэсэгтээ алслагдсан цөөн цэцэгтэй. Дагавар навч шовх, нүцгэн цоморлигоос богино. Дэлбэ бор өнгөтэй. Хонхорцог цоморлигоос 2 дахин урт, 4-5 хааяа 3 үртэй.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин: Уулын хээрийн чулуурхаг бэл хормой, хажуу, эргийн марзлаг нуга, элс хайрга, дэрсэн шугуй түнхэт нуга сайрын оёор мөн зам харгуй, орон байрны дэргэд, тариалангийн талбай, атаржсан газарт ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: 6-8сар

Цэцэглэж дуусах хугацаа: 8-9 сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн үнэлгээ- Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал

ОДОЙ ХАЙЛААС

Латин нэр: *Ulmus pumila* L.
Англи нэр: Siberian Elm



УРГАМЛЫН ШИНЖ:

Нвцгэн, нарийн найлзууртай, шаргал саарал холтос бvхий 3-4-өөс 12-15 метр өндөр мод. Өндгөрхvv гонзгой арьсархаг навчтай. Навчны хоёрдогч судал нь ихэвчлэн салаа үзvvртэй. Навчны зах энгийн буюу хааяа салаа шvдтэй. Хайлаас нь гол иш титэм саглагар шүхэр хэлбэртэй мод. Манай орны нөхцөлд дунджаар 10 орчим метр өндөр ургадаг. Насны хувьд янз бүр бөгөөд заримдаа 200 гаруй насных ч тохиолдоно. Хайлаасны бүдүүн ургах орчны нөхцөлөөс хамаарч янз бүр байх ба дунджаар 30 см бөгөөд зарим газарт 50 см бүдүүнтэй я ургана. Залуу найлзуур, мөчир нь ногоон шар өнгийн холтостой. Хөгшин модны холтос саарал өнгөтэй. Навч нь өргөн юлдэрхүү, арьслаг, бараг тэнцүү талт суурьтай, энгийн шүдлэг хааяа давхар шүдлэгтэй, навчны голоос хоёр тийш гарсан тэгш тод хээтэй.

Амьдралын хэлбэр: Олон наст модлог ургамал

Ургах орчин: Хуурайдуу, цөлөрхөг хээр болон хур тунадас бага ордог орчинд голдуу ургана. Хөрс нь сийрэг үржил шим муутай, хад асгатай хайргадуу, уулын хад болон чулуутай бэл, ам хавцал түүний ёроол, сайрын хөвөө, голын эргийн элсэрхэг хөрсөнд зонхилон тохиолдоно.

Цэцэглэж эхлэх хугацаа: IV сар

Цэцэглэж дуусах хугацаа: V сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн

ОЛСЛИГ ХАЛГАЙ

Латин нэр: *Urtica cannabina* L.

Англи нэр: Hemp nettle



УРГАМЛЫН ШИНЖ:

70-150 см өндөр, бүдүүн мөлхөө үндэстэй, 4 талт, булчирхайт болон энгийн үсэнцэртэй. Навчис олон дахин гүн цуурсан өдлөг, хэрчмэл, салбан үүсгэдэг сарвуулаг илтэстэй, 2 талдаа энгийн үслэг авч доод талын судлыг дагаж түлдэг үстэй. Дагавар навч урт, сарьслаг, юлдэрхүү. Цэцэг ногоон, залаархуу түрүүнд нэгддэг.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал

Ургах орчин: Уулын хуурай хад чулуу, бутармаг чулуут хажуу, бул чулуун дунд, хажуу хормойн адаг, нураг, горхи булгийн эрэг, сийрэг хуурай ой, мөн бууц нутаг, орон байрны ойролцоо ургадаг.


Цэцэглэж эхлэх хугацаа: VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VIII сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн



БУУРАЛ ГАНДБАДРАА

Латин нэр: *Veronica incana* L.

Англи нэр: silver speedwell



УРГАМЛЫН ШИНЖ:

10-30 см өндөр. Мөлхөө үндэслэг иштэй. Ургамал бүхэлдээ цайвар-эсгийрхэг үсэрхэг. Иш эгц босоо. Ишний суурийн навчис зувануртавтар юм уу юлдэн-уртавтар хэлбэртэй, бүтэн захтай, мохоо оройтой, нарийн шаантган хэлбэрийн суурьтай, аажим нарийссан богиновтор бариул болдог. Ишний навчис цувраа байрлалтай, юлдэрхүү хэлбэртэй. Дэлбэ бараандуу хөх өнгөтэй, хэлтсүүд өндгөрхүү юм уу уртавтар хэлбэртэй, 3 мм урт ба мохоо. Дэлбийн хоолойд булчирхайт цагираг үслэгтэй. Хонхорцог хажуугаасаа нарийссан, дугаригзуван хэлбэртэй, 3 мм урт, богино үсэрхэг.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс
Ургах орчин: Уулын хээржүү хажуу, хээрийн нуга, хуурай шинэсэн болон нарсан ой, тэдгээрийн зах, хад асганд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VIII-IX сар


Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 51 хоног.

Балын төрөл: Олон зүйлийн

Тоосны нөөц-0.015 г, балан нөөц-0.024 г.

Зөгийн аж ахуйн үнэлгээ- Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал



ӨРГӨН НАВЧИТ ТАЙЖИЙН ЖИНС

Латин нэр: *Echinops latifolius* Tausch.


Англи нэр: Ballflower Globethistle, Common Globethistle, Great Globethistle, Globe-thistle



УРГАМЛЫН ШИНЖ:

Иш 30-80 см өндөр, эгц босоо, торлосон юм уу эсгийрхэг үслэгээр хучигдсан. Навчис хошоод өдлөг цуулбар. Навчны судлууд хурц өргөстэй. Түүний дээд гадаргуу бага зэрэг үслэгтэй, доод тал эсгийрхэг үслэгтэйн улмаас цайвар цагаан өнгөтэй. Толгойрхуу хэлбэрийн 4-6 см голчтой баг цэцэг үүсгэнэ. Цэцэг хөх цэнхэр өнгөтэй. Үр жимс үрэнцэр хэлбэртэй.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг
Ургах орчин: Элдэв өвст болон үетэн-элдэв өвст хээр, хайрга чулуутай энгэр, хуурай нуга, хад асганд ургана.
Цэцэглэж эхлэх хугацаа: VII сар
Цэцэглэж дуусах хугацаа: VIII сар
Цэцэглэлт үргэлжлэх өдөр:
Балын төрөл/ нэг төрлийн:
Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал
Таримал/Байгалийн: Байгалийн ургамал



ТОМ НАВЧИТ ДЭГД

Латин нэр: *Gentiana macrophylla* Pall.

Англи нэр: Gentian



УРГАМЛЫН ШИНЖ:

10-30 см өндөр. Цэцэг 1.5-2 см урт дээд навчисын өвөрт толгойлсон бөөн, цоморлиг 6 мм орчим урт, хөх ягаан дэлбээсээ гурав дахин богино, маш богинохон юм уу мэдэгдэх төдий шүдтэй, бүтэн юм уу дундаа хүртэл хэлтгий хэрчигдмэл навчтай.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин: Шинэсэн ба холимог ой, ойн захаар, эргийн боролж, гол горхины эрэг хөвөөнд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Балын төрөл: Олон зүйлийн

Тоосны нөөц: 0.018 г, **балан нөөц:** 0.054 г.

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал

УРТНАВЧИТ ГАНДБАДРАА

Латин нэр: *Veronica longifolia* L.

Англи нэр: Long-leaf spike speedwell



УРГАМЛЫН ШИНЖ:

Иш 70-80 см өндөртэй, дугариг хөндлөн огтлолтой, дундаасаа дээш салаалсан, доод хэсэгтээ сийрэг дээд хэсэгтээ өтгөн үслэгтэй. Мөлхөө, нарийхан утсархаг үндэстэй иштэй. Навчис эсрэг суусан байрлалтай, уртавтар-юлдэрхүү хэлбэртэй, 12 см хүртэл урт, 2-3 см хүртэл өргөн, дээд хэсгийнх 1-3 мм, доод хэсгийн навчис 1 см хүртэл урт бариултай, том хурц давхар хөрөөн шүдлэг захтай, урт шовх оройтой. Дагавар навч шугаман-утсархуу, цэцгийн шилбэтэй тэнцүү юм уу түүнээс богино. Дэлбийн хэлтэс бараан хөх өнгөтэй, уртавтар юм уу өндгөрхүү хэлбэртэй, мохоо.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин: Ойн болон өндөр уулын бүслүүрт шинэсэн ой тэдгээрийн зах, ойн болон эргийн нуга, гол горхийн эрэг, эргийн ой, бургасан шугуйд ба сөөгөн дунд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 29 хоног.

Балын төрөл/ нэг төрлийн: Тоосны нөөц- 0.062 г, балан нөөц- 0.078 г. Зөгийн аж ахуйн үнэлгээ- Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал

ХУЛГАНЫН ГИШ

Латин нэр: *Vicia cracca* L.

Англи нэр: Tufted Vetch, Bird Vetch, Cow Vetch, Canada pea



УРГАМЛЫН ШИНЖ:

Цацаг 20-40 цэцэгтэй. Навчны дагавар 6-10 мм урт, бүтэн хааяа 1-2 шүдлэгтэй. Навчинцар 6-10 хос, шугаман юлдэрхүү юм уу гонзгой юлдэрхүү, үзүүртээ шөвгөр шовх юм уу дугариг хааяа өтгөн үсэрхэг саарал өнгөтэй. Дэлбэ ягаан юм уу нил хааяа цагаан.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг буурцагтан

Ургах орчин: Уулын голын хөндий, чулуурхаг хажуу, сайрын чулуурхаг ирмэг, ёроол, хад чулуу, нураг элсэрхэг хээр, эргийн элсэнд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар


Цэцэглэж дуусах хугацаа: VIII-IX сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 51 хоног.

Балын төрөл: Олон зүйлийн Тоосны нөөц -2.577 г, балан нөөц- 0.054 г.

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал



ХЭВТЭЭ ДЭГД

Латин нэр: *Gentiana decumbens* L.f.

Англи нэр: Gentian



УРГАМЛЫН ШИНЖ:

10-30 см богинохон бүдүүн нэлээд салаалсан үндэслэг иштэй. Ишний ёзоор өнгөрсөн жилийн навчны үлдэгдлээр өвч хучигдсан. Үндэс орчмын навчис шугамархуу-юлдэн, 3-5 судалтай, ишнийх нь арай жижиг, 2-4 хос. Цэцэг ишний үзүүрт, ишний дээд хэсгийн навчны өвөрт байрлана, хааяа 2-5 аараа оройн баг цэцэг бүрдүүлнэ. Цэцгүүд нарийн юлүүрэрхүү, гүн хөх өнгөтэй, 30-35 урт. Цоморлиг нэг талдаа гүн цуулбар нэг талдаа оршдог богино 1-5 мм шүдлэгүүдтэй, хааяа огт шүдлэггүй, ягаавтар юм уу цайварногоон өнгөтэй. Үрэвч юлдэн хэлбэртэй, богино шилбэтэй.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг алаг өвс

Ургах орчин: Ойт хээр, хээр, цөлийн хайргат хээр, чулуурхаг хажуу, байц хадны ёроолд ургана.


Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал



ЦОМЦОГТ БААВАР ЦЭЦЭГ

Латин нэр: *Scabiosa comosa* Fisch. Ex Roem. & Schult.

Англи нэр: Scabiosa butterfly blue



УРГАМЛЫН ШИНЖ:

40-50 см өндөр, богино, салаалсан, сахлаг үндэстэй олон наст өвслөг ургамал. Үндэс орчмын болон үржлийн бус найлзуурын навчис юлдэрхүү хэлбэртэй, бүтэн эсвэл хэрчигдсэн шүдлэг, үржлийн ишний навч өдөлж хуваагдсан. Цэцэг хөх хааяа ягаан өнгөтэй, толгой баг цэцэг үүсгэдэг.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал

Ургах орчин: Ойт хээрийн бүслүүр, хээрийн бүсийн тал хээр, хээрийн ба алаг өвс нуга, сөөг дунд, хээрийн чулуурхаг, үйрмэг чулуут хажуугаар ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VIII сар


Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 43 хоног

Балын төрөл: Олон зүйлийн

Балан нөөц: 0.025 г.

Зөгийн аж ахуйн үнэлгээ: Амтат шүүст-тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн



ХАР ЛАНТАНЗ, ТЭНЭГ ӨВС, СОГТУУ ӨВС

Латин нэр: *Hyoscyamus niger* L.
Англи нэр: black henbane



УРГАМЛЫН ШИНЖ:

Иш 20-115 см өндөр, бадриун, мөчир салаа ихтэй, цавуурхаг, сэрвэгэр үсэрхэг, эвгүй үнэртэй. Навчис зуувгар, онин шүдлэг, онин-ухалбар учир хурц салбангуудтай. Хааяа бүтэн, ишний оройн навчис суумал, гонзгой юлдэрхүү, ишний ёзоорын навчис урт бариултай, гонзгой өндгөрхүү юм уу зуувгар. Цэцэг суумал бөгөөд иш, мөчрийн үзүүр дэх цацаг үүсгэдэг. Цоморлог 10-22 мм урт, цэцэглэх үед хонхордуу, жимслэх үест томорч домборхуу болж цүлхийнэ. Дэлбэ 25-40 мм урт, юүлүүрэрхүү, цагаан-халтар юм уу зэвхий шаравтар өнгөтэй, хөх ягаан судалтай, завьжин дээрээ бүдэг хөх ягаан. Дохиурын шилбэ үсэрхэг бөгөөд олон жижиг үртэй, ямагт таглаагаар нээгддэг.

Амьдралын хэлбэр: Хоёр наст ургамал

Ургах орчин: Тариалангийн талбай, атаржсан газар, хүнсний ногооны талбай, суваг шуудууны эрэг, хөвөө, замын хажуу, орон байрны ойролцоох халцгай газар өвөлжөө бууцны өтөг, хогтой газар, голын эрэг, хуурай хайрганд ургадаг.

Цэцэглэж эхлэх хугацаа: VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VIII сар

Балын төрөл: Олон зүйлийн Зөгийн аж ахуйн үнэлгээ-Амтат шүүст-гоост ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн



ЦАЙВАР ШАРГАЛ ЦАГААН ТҮРҮҮ, УУЛ ӨВС

Латин нэр: *Leontopodium ochroleucum* Beauvd.

Англи нэр: Edelweiss

УРГАМЛЫН ШИНЖ:

Иш 3-35 см өндөртэй, эгц босоо ганц нэгээрээ юм уу хэд хэдээрээ, эгц босоо бөгөөд бат бөх, цайвар өнгийн халцардаггүй үслэгээр өтгөн бүрхэгдсэн, жигд өтгөн навчирхаг. Өтгөн нарийхан үндэс бүхий богиноссон үндэслэг иштэй, үржилгүй найлзуурын навч нэлээд сийрэгдүү дэгнүүл үүсгэдэг. Навч гонзгой юм уу шугаман-юлдэрхүү хэлбэртэй, мохоовтор юм уу хурц үзүүртэй, ишнийх 2-6 см урт, 2-10 мм өргөн, үндэс орчмынх 10 см урт, 13 мм өргөн, бүх навчны дээд гадаргуу эсгийрхэг-цайвар үсэрхэг, доод гадаргуу эсгийрхүү үнсэн цагаан үсээр хучигдсан. Одорхуу хэлбэрийн дагавар навчин дээр сагснууд шигүү сууж баг цэцэг үүсгэн байрладаг. Цомцог богинохон, 3.5-5 мм урт.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг
Ургах орчин: Уулархаг хээрээс өндөр уулын бүслүүр хүртэл ургана.
Цэцэглэж эхлэх хугацаа: VII- сар
Цэцэглэж дуусах хугацаа: VIII сар
Балын төрөл: Олон зүйлийн
Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал
Таримал/Байгалийн: Байгалийн

ЭГЭЛ ЦАГААН ТҮРҮҮ

Латин нэр: *Leontopodium leontopodioides* (Willd.)
Beauvd.

Англи нэр: Northern edelweiss



УРГАМЛЫН ШИНЖ:

Бүхэлдээ саарал торгомсог юм уу хааяа үнсэн саарал бөөгнөрсөн үслэгтэй ургамал. Навч дээшээ чиглэсэн, иш рүүгээ ханарсан, үзүүртээ хурц хатуу. Жижиг сагснууд ишний дээ хэсэгт од үүсгээгүй 3-4 нарийвтар дагавар навчин дээр сууж байрладаг. Цомцог урт, баргар цагаан өнгөтэй, дохиурт цэцгийнх 4 мм-с урт, үр боловсрох оронт цэцгийнх 6.5 мм урттай байна.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг
Ургах орчин: Хээр талд хээржүү хажуу ба хуурай нуга, хайрга чулуутай хээржүү хажуу, хуурай шинэсэн ой ба туж нарсанд ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VIII-IX сар

Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 31 хоног.

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал

БАГА ХУРГАН ЧИХ

Латин нэр: *Rumex acetosella* L.
Англи нэр: Sheep's sorrel

УРГАМЛЫН ШИНЖ:

Шадар эрхтэн жимслэх үед бараг томрохгүй, зөвхөн самранцараасаа арай илүү болдог. Цэцэг дан бэлэгтэй, урт тасалданги баг цэцэгтэй. Үндэслэг иш, мөлхөө.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал.

Ургах орчин: Голын эрэг, эргийн хайрга, чийглэг марзат нуга, эргийн ой, эргийн элс, манхад ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: V

Цэцэглэж дуусах хугацаа: IX

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Амтат шүүст-тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн

ӨМХИЙ БУРЖГАР

Латин нэр: *Carex duriuscula* C.A. Mey
Англи нэр: Needleleaf Sedge



УРГАМЛЫН ШИНЖ:

15-100 см өндөр. Иш олон салаалсан эсвэл энгийн. Навч богино бариултай, дагавар навч сарьслаг, илтэс гурвалсан өдлөг, 5.5-12 см өргөн, өндгөрхүү, энгийн эсвэл булчирхайт үслэгтэй. Баг цэцэг шүхэр, цөөн эсвэл олон цэцэгтэй. Цоморлиг 5, шар, ногоон холилдсон, өндгөрхүү, захаараа үсэрхэг. Дохиурын шилбэ сууриараа хялгасан, үзүүр өргөн шугаман, тоосовч 2.5-3.5 мм, үзүүр шовх. Үр боловсрох орон 4-7, амсар гурвалжин далавчирхуу. Үр тонгоруу өндгөрхүү, өргөшөө шахагдсан, 3-5 мм, энгийн үслэгтэй.

Ургах орчин: Хээрийн үйрмэг чулуут, чулуурхаг хадтай хажуу, хуурай сийрэг шинэсэн ой, тэдгээрийн захаар ургана.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал

Цэцэглэж эхлэх хугацаа: V сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII сар

Балын төрөл: Олон зүйлийн

Зөгийн аж ахуйн ангилал: Тоост-амтат шүүст ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн



ШИРЭГ УЛАЛЖ

Латин нэр: *Carex duriuscula* C.A. Mey
Англи нэр: Yellow meadow rue

УРГАМЛЫН ШИНЖ:

Иш 5-20 см өндөр, саарал ногоон өнгөтэй. Богиноссон үндэслэг иштэй, сийрэг дэгнүүл үүсгэдэг. Найлзуурын угийг хучсан угларга бор саарал, тууш ширхэгтэй. Шадар хайрс хүрэн, ирмэгээрээ сарьслаг, аажимдаа өнгөгүй болдог. Уутанцар өндгөрхүү, үзүүрээдээ нарийсаж шонтон үүсгэдэг.


Ургах орчин: Элсэрхэг тэгш тал, уулын хээр, гол горхины эргийн чийглэг, хужирлаг нуга, чулуурхаг хажуу, бэлчээрт ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI сар

Цэцэглэж дуусах хугацаа: VI-VII сар

Балын төрөл /Нэг зүйлийн/: Зөгийн аж ахуйн үнэлгээ- Тоост ургамал


Таримал/Байгалийн: Байгалийн



ЭМИЙН СӨД, СӨД ӨВС

Латин нэр: *Sanguisorba officinalis* L.

Англи нэр: Greater burnet



УРГМАЛЫН ШИНЖ:

Бүдүүн үндэслэг иштэй, 20-110 см өндөртэй. Иш нүцгэн юмуу доод хэсэгтээ үсэрхэг. Навчис 4-6 хос навчинцар бүхий өрөөсгөл өдлөг, навчинцарууд уртавтар-өндгөн юмуу зууван, хөрөөн шүдэрхэг, урт байриултай, доод гадаргуу нүцгэн юмуу үсэрхэг. Дан шадар эрхтэн бүхий хүрэн улаан өнгийн цэцэгнээс бүрдсэн толгой баг цэцэгтэй. Багцэцэг зууван зууван бөөрөнхий хэлбэртэй, 10-20 мм урт, 8-15 мм өргөн. Дохиурын шилбэ улаан өнгөтэй, цоморлогийн навчинцраас уртгүй.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал

Ургах орчин: Хээрийн бүсээс өндөр уулын бүслүүр хүртэл алаг өвст, татмын, намгархаг ба хээрийнн нуга, гол, булгийн эрэг, голын сөөгөн шугуй, шинэсэн төгөл, тэдгээрийн зах, ойн нуга, хусан төгөлд ургана.


Цэцэглэж эхлэх хугацаа: VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VIII сар

Балын төрөл: Олон зүйлийн Балан нөөц-0.022 г

Зөгийн аж ахуйн ангилал: Тоост ургамал

Таримал/Байгалийн: Байгалийн



МАНЖ ГАНДИГАР

Латин нэр: *Sambucus manshurica* Kitag.

Англи нэр: Red elder

УРГАМЛЫН ШИНЖ:

1-4 м өндөр. Мөчир ягаавтар хүрэн өнгөтэй, зөөлөн голтой сийрэг үсэрхэг. Навчисэсрэг суусан байрлалтай, өрөөсгөл өдлөг нийлмэл, 2-3 хос навчинцартай, 5-9 см урт нүцгэн, доод гадаргуу бүүдгэр ногоон өнгөтэй, навчинцрын илтэс өндгөрхүү-юлдэн хэлбэртэй, хөрөөн шүдлэг захтай, уртассан шовх оройтой. Цэцэг жижигхэн, давхар шадар эрхтэнтэй, өтгөн бамбайрхуу-залуу баг цэцэг бүрдүүлдэг. Дэлбийн хэлтэс зуувгар, цагаан шаргал өнгөтэй. Дохиур 5 юм уу 4. Яст жимс хурц улаан, бөөрөнхий, 4 мм орчим голчтой.

Амьдралын хэлбэр: Сөөглөг

Ургах орчин: Ойн бүслүүр болон өндөр уулын доод хэсгээр голын эрэг дагуух ой, хавцлын оёор, асгарга чулуу, нураг, эргийн сөөгөн шугуй, ойн захаар ургана.

Цэцэглэж эхлэх хугацаа: VI-VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VII-VIII сар

Балын төрөл: Зөгийн аж ахуйн үнэлгээ-Тоост амтат шүүст ургамал.

Таримал/Байгалийн: Байгалийн ургамал

ОДОЙ САРААНА, УЛААН САРААНА

Латин нэр: *Lilium pumilum* Delile.

Англи нэр: Siberian Lily

УРГАМЛЫН ШИНЖ:

40-60 см-аас 1 м хүртэл өндөр ургадаг, нарийхан гөлгөр иштэй. Сонгинолог булцуу 3-4 см өндөр, өндгөрхүү хэлбэртэй, цагаан өнгөтэй, саарал хальстай. Нарийн шугамархуу хэлбэртэй, 3-10 см урт, навч иш дээр цувраа байрлалаар суусан. Дан шадар эрхтэнтэй. Дэлбийн хэлтэс 6, эргэж нумарсан гонзгой юлдэрхүү хэлбэртэй, тод улаан өнгөтэй. Дохиур 6, ҮБО 1, хонхорцог хэлбэрийн үр жимстэй. 2-6 цэцэгс уртавтар шилбээр ишний оройд цацаг баг цэцэг бүрдүүлнэ.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал
Ургах орчин: Чулуурхаг болон нугархаг уулын хажуу, нарсан ой, ойн зах, хуурай элс-хайрган хөрстэй орчинд ургана.

Цэцэглэж үрлэх хугацаа: VII сар

Цэцэглэж дуусах хугацаа: VIII сар


Цэцэглэлт үргэлжлэх өдөр: 51 хоног

Балын төрөл: Олон зүйлийн

Тоосны нөөц: 0.257 г

Зөгийн аж ахуйн ангилал: Тоост ургамал

Таримал/ Байгалийн: Байгалийн



ГЭРЭЛ ЗУРГИЙГ

© Алексей Малиновских (Алтайн согсоот)

© Анна Барма (Нүцгэн намуу)

© Ө. Баярсайхан (Сибирь зүрхэн цэцэг, Царсан Гүүн хөх, Гогод, Улиангар, Гоо улаагана, Монгол чаргай, Дэрэвгэр жиргэрүү, Манж Гандигар)

© Л. Бямбацэцэг (Их шүүдэргэнэ, Марал навчит гичгэнэ, Эгэл төлөгч өвс, Бунгийн банга, Цацагт үлд өвс, Эмийн сөд, Монгол догар, Баг хонхон цэцэг, Имт гичгэнэ, Буурал гандбадра, Хонгор зуллог хонгорзалааа, Власовын шимтэглэй, Өргөст нохойн хошуу)

© Н. Батсайхан (Ойн дурсгалж цэцэг, Цагаалин цахилдаг, Одой хайлаас)

© Б. Гантулга (Цомцогт Баавар цэцэг)

© В. Гүндэгмаа (Дорнодын гүзээлзгэнэ, Енисейн Шээрэнгэ, Өрөл, Умардын далан товч, Хар үрт Чаргай, Час улаан долоогоно, Алеппийн малтууш, Бага буржгар, Британ зоосон цэцэг, Гоёмсог хувиланги, Дагуур хатны цэцэг, Жинхэнэ шар өрөмтүүл, Ишгүй гичгэнэ, Ленийн Шар дэмэг, Судалт хувиланга, Хадны сэрхлиг, Шар хувиланга, Шар царгас, Энгийн буржгар, Бар цоохор цахилдаг, Нугын шимтэглэй, Сибирь шимтэглэй, Түмэн навчинцарт ортууз, Утсан ортууз, Үнэгэн сүүлхэй тарна, Нумраа хунчир, Хадны бөгтөргөнө, Долгиотсон гишүүнэ, Олслиг халгай, Уртнавчит Гандбадраа, Хар лантанз, Цайвар шаргал цагаан түрүү, Өмхий буржгар, Бага хурган чих, Азийн монос, Алтайн түмэн тана, Гогод, Завадскийн тунхуу өвс, Өрөл, Сарвуун сонгино, Галуун гичгэнэ, Имт гичгэнэ, Монгол хунчир, Нарийн навчит харгана, Булцуут туйпланцар, Бургас навчит тавилгана, Нарийн навчит зүрхэн цэцэг, Сибирь гүйлээс, Үлдэн могойн идээ, Тагийн гол гэсэр, Цагаалин цахилдаг, Өргөн навчит тайжийн жинс, Хэвтээ дэгд)

© Б. Мөнхчулуун (Эмийн сөд, Одой Сараана, Ацан ажигана, Эмийн бамбай, Австрийн Хависхана, Бага Хумхаал, Нүцгэн намуу)

© Надежда Васильевна Степанцова (Дэлхээ сонгино, мангина)

© Наталья Гамова (Буриад гоньд)

© Г. Сэлэнгэ (Бариулт бүйлээс)

© Г. Сайнбаяр (Нарийн навчит хөвөнт)

© Б. Оюунцэцэг (Тэхийн шээг, Дагуур тарваган шийр, Хоёр ишт Бэриш, Шар царгас, Говийн ганга, Нумраа хунчир, Азийн монос. Дунд тавилгана, Монгол чаргай, Хависхана навчит Бэриш, Бургас навчит Банздоо, Хиазтай хонгорзалаа, Цуулбар нил, Байгаль Гүүн хөх, Навтгар таван салаа, Ширэг улалж)

© М. Ууганбаяр (Хижээл сонгино, Үхэр тарна, Мөлхөө Шээрэнгэ, Ацан ажигана, Бунгийн яргуй, Хошоон хунчир, Власовын шимтэглэй, Хөдөөгийн сэдэргэнэ, Сибирь хотой, Хөдөөгийн батраш, Буриад хонин зажлуур, Алтанзул, Сарвуун сонгино, Ацан цахилдаг, Цацагт үлд өвс, Улбалзуур могойн идээ, Намгийн дүндэггарав, Сибирь Гүйлс, Хулганын гиш, Өргөн навчит тайжийн жинс, Эмийн бамбай, Монгол догар, Сибирь зираа, Завадскийн тунхуу өвс, Азийн төлөгч өвс, Эмийн багваахай, Тагийн гол гэсэр, Баг хонхон цэцэг, Нарийн цэцэгт хонхлой, Дагуур хатны цэцэг, Байгаль Гүүн хөх, Булцуут туйпланцар, Хэвтээ дэгд, Гоо юлд, Нарийн навчит зүрхэн цэцэг, Нугын шимтэглэй, Орос царгас, Уралын чихэр өвс, Нарийн навчит харгана, Бургас навчит тавилгана, Дунд тавилгана, Хонгор зуллог хонгорзалаа)

© С. Энхчимэг (Одой Сараана; Улаан сараана, Шар гонтог, Цомцогт Баавар цэцэг, Зөөлөннавчит үлд өвс, Шивүүрт үлд өвс, Цэх түмэн тана, Өргөст нохойн хошуу, Бяцхан навчит харгана, Шошлойрхог хошоонгор, Бага Хумхаал, Алтанзул, Ацан цахилдаг, Нүцгэн намуу, Цацагт үлд өвс, Ишгүй гичгэнэ, Эмийн бамбай, Сибирь зираа, Эмийн багваахай, Гоо юлд, Хоёр ишт Бэриш, Орос царгас, Уралын чихэр өвс, Галуун гичгэнэ, Дэрэвгэр жиргэрүү, Буурал гандбадраа)

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Баягмөнх, Т., Төгөлдөр. Э., Шинэцэцэг, М. (2014). Тосон Хулстайн голлох ургамлууд. Улаанбаатар.
2. Бадамцэцэг, Б., Дариймаа, Ш., Lee Sang Myong. (2013). Монгол орны зарим ургамлын таних гарын авлага. Korean Government (MSIP)
3. Дариймаа, Ш., Пунсалпаамуу, Г., Хонгорзул, Ц., Баянмөнх, Т., Гүндэгмаа, В., Цэрэнням, Ж., Сайндовдон, Д. (2014). Шатан орчмын зонхилох цоргот ургамал. Улаанбаатар.
4. Монгол орны эмийн ургамлыг Өрнө Дорнын анагаах ухаанд хэрэглэхүй “У. Лигаа” Улаанбаатар 2015
5. Очирбат, Г. (2007). Монгол орын балт ургамлын нөөц. Улаанбаатар.
6. Очирбат, Г. (2019). Монгол орын балт ургамлын нөөц. Улаанбаатар. 2 дахь.хэв. Боть4.
7. Очирбат, Г. (2019). Ургамал, зөгийг судлагч. УБ. 2019. 309 тал.
8. Очирбат, Г. (2009). Ургамал судлал орчин зүйн толь бичиг. Улаанбаатар.
9. Флора СССР.2. Л., 1934.
10. Флора СССР.4. Л., 1935.
11. Флора СССР.8. Л., 1939.
12. Флора СССР.10. Л., 1941.
13. Губанов, И. А. (1996). Конспект флоры Внешней Монголии (сосудистые растения). – М: «Валанг» - 136 с. 5. Грубов, В. И.
14. Urgamal, M. Oyuntsetseg, B. Nyambayar, D. Dulamsuren, Ch. (2014). Conspectus of the vascular plants of Mongolia. Ulaanbaatar: Admon Printing.
15. Useful flowering plants in Mongolia 2016 year Citation Ganbold E. et al., 2016 Useful flowering plants in Mongolia. Korean Research Institute of Bioscience & Biotechnology, Daejeon, Republic of Korea. 325 pages

ХАР ЯМААТЫН БАЙГАЛИЙН НӨӨЦ ГАЗАР

50.691 мян. га

Хар ямаатын байгалийн нөөц газар нь 50,691 мян. га нутаг дэвсгэртэй.

1998 он

УИХ-ын 1998 оны 28-р тогтоолоор "байгалийн нөөц газар" ангиллаар улсын тусгай хамгаалалтад авсан.

2013 он

БОНХЯ-тай байгуулсан гэрээний дагуу 2013 оны VII сараас эхлэн Хар ямаатын БНГ-ын менежментийг Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар хариуцан ажиллаж байна.

2

Хэнтий болон Сүхбаатар аймгийн хил залгаа Түмэнцогт (нутаг дэвсгэрийн 0,04%), Баян-Овоо (12%) сумдын нутгийг дамнан оршдог.

58.3%

Хялганат хээрийн экосистем нь БНГ-т 29,674.4 га буюу нөөц газрын 58,3%-ийг хамарч байна.

10+

БНГ-ын хойт хилийн дагуу урсаж өнгөрдөг Хэрлэн гол нь олон улсын хэмжээнд ховордсон, ховордож болзошгүй, Монгол улсын Улаан номд орсон 10 зүйл шувуудын дайран өнгөрдөг чухал газар нутаг юм.

ISBN: 978-9919-9565-5-4



9 789919 956554